

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн ХШҮ-ний тайлан

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

ИТХ-д танилцуулах 2023.05.09

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1. НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ							
1	1.1. Соёлын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, өсвөр үе, залуучуудад сурталчлан таниулах, соёлын	1.1.1. Түүх, соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна.	2021 - 2025			Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг тооллогыг амжилттай зохион байгуулж Улсын хамгаалалтай 13, Аймгийн хамгаалалтай 53 дурсгалт газрын Улсын тооллого-2022” хээрийн үзлэг судалгаанд 20 сумын нутаг дэвсгэрт нийт 346 дурсгалт газрын 4517 дурсгалыг тооллогод хамруулахаас 333 дурсгал тоологдож бүртгэлийн RICH 3.0, www.rich.mongoluv.mn программд тус тус бүртгэн аймгийн хэмжээнд 96.24 % хувьтай явагдаж дууссан. Мөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг ойролцоох айлуудад гэрээгээр хамгаалуулах ажлыг хийсэн Монгол Улсын Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Соёл,урлагийн газрын даргын тушаал 2022 оны А/42 тоот тушаалаар Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг зохион байгуулах ажлыг Аймгийн Засаг даргын 2022 оны А/652 тоот захирамжаар тооллогын ажлын хэсэг томилж бүсчилсэн судалгаа хийж нийт 315 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хамрагдахаас 202 өвлөн уламжлагчаас 3 багц төрлийн 55 асуулгаар судалгааг авч ажиллалаа. Аймгийн хэмжээнд 20 сумын ардын авьяастнуудын дунд соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлж, олон нийтэд хүргэх	

	салбарын хүний нөөцийг чадавхижуулна.				зорилго бүхий урлагийн бага наадам зохион байгуулж нийт 120 гаруй өвлөн уламжлагчдыг оролцуулж "Нүүдэлчин монгол" наадамд Баянхонгор аймгаас 60 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 7 ай савын төрлөөр оролцож 3 төрөлд шагналт байр эзлэн соёлын биет бус өвийг олон нийтэд сурталчилсан.	
2	1.1.2. Соёл, урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тэдний ур чадвар, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.	2021 - 2025			Соёл урлагийн салбарын албан хаагчдыг 3-4 удаагийн цахим болон танхимын сургалтад хамруулж давхардсан тоогоор 458 хүн хамрагдаж, 6 сумыг мэргэжлийн хөгжмийн багш, эрхлэгч, орон нутаг судлах танхимын ажилтнаар хангаж, Хөгжимт драмын театрын 4 бүжигчнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж мэргэжлийн боловсон хүчний хангалт 64 хувьд хүрч өмнө оноос 7 хувиар нэмэгдсэн.	
3	1.1.3. Соёлын салбарын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгож, иргэдийг соён гэгээрүүлж, хандлагыг өөрчлөх замаар хувь хүний, гэр бүлийн, байгууллагын соёлын дархлааг нэмэгдүүлж, "Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025			"Соёлтой-Хонгорчууд" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх сум, орон нутгийн иргэдээс авсан иргэдийн соёлын боловсролын түвшин тогтоох судалгааг 20 сумын нийт 1050 гаруй иргэдээс судалгаа авч нэгтгэн дүгнэлт гаргасан. "Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх ажил арга хэмжээг сар бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган үе шаттай зохион байгуулж "Соёлын бүтээлч сар" аяныг гурван зорилтын хүрээнд 30 үйл ажиллагаа, 97 арга хэмжээгээр 22633 хүнд соён гэгээрүүлэх соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулан, нутгийн онцлог өв соёлоо таньж мэдэх, өвлүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх ажлуудыг зохион байгуулсан.	

4	1.1.4. Соёл, урлагийн байгууллагуудын барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, соёлын төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, иргэн бүрт хүрч үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	2021 - 2025			Хүүхдийн Тэмүжин театрыг нэн шаардлагатай 16 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр, Байгалийн түүхийн музей, болон түүх угсаатны зүй музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах дохиолол хамгаалалтын системийг шинэчлэх, зарим эд зүйлсийг хамгаалалтад авах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн хөгжимт драмын театрын 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зорилтот ажлын хүрээнд Хөгжимт драмын театрын нүүрэн талын их засварын ажлыг хийж, гэрэлтүүлгийг шинэчилж гадна орчны тохижилтыг сайжруулсан.	
5	1.1.5. Иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, сумдын номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна.	2021 - 2025			Улс болон орон нутгийн төсвийн 24.250.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийтийн номын сан болон сумдын номын сангуудыг ном хэвлэлээр хангаж сан хөмрөгийн баяжилтыг хийж уншигчдын тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж “Номын баяр”, “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд “Урилгатай уншлага” аяныг өрнүүлж 3715 иргэнийг цахимаар болон танхимаар хамрууллаа. Мөн соёл, танин мэдэхүй, соён гэгээрүүлэх 55 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулан 8578 хүнд үйлчилсэн байна.	
6	1.1.6. Аймгийн түүхийн музейн барилгыг ашиглалтад оруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн биет болон биет бус	2021 - 2025			Аймгийн музейн барилгын ажил зураг төсөл хийгдсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар санхүүжилт шийдэгдээгүй учраас барилгын ажил эхлээгүй.	

		өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна.				
7	1.2. Хүүхэд, залуучуудын эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлж, Монгол ахуй, ёс заншил, өв	1.2.1. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		ГБХЗХГ-аар үчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 20 сумын 10623 өрхөд сурталчилсан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор "Хайр түгээе" цахим нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж арга хэмжээний хүрээнд "Хуулиа мэдье" сургалтыг 352 иргэнд зохион байгуулсан. Эерэг хандлага афоризм 2 ширхэгийг бэлтгэн олон нийтийн сүлжээгээр цацсан. Нийт хандалтын тоо 2156. 05 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 19 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 1 нэгжээр буюу 5.5%-иар өссөн. Зөрчил 80 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 3 нэгжээр буюу 3.9%-иар өссөн дүнтэй байна. Гэмт хэрэг, зөрчлийн тоо өссөн нь илрүүлэлт сайжирсантай холбоотой гэж дүгнэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалж байна. Төрийн байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүдэд зөвлөн туслах арга хэмжээ, сургалтыг 3 удаа зохион байгуулж төрийн 235 байгууллагын ажилтан албан хаагчид хамрагдсан.	
8	уламжлал, хэл бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	1.2.2. Хүүхэд, залуучуудын Монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, "Цахим соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025		Монгол хэлний хичээлээр ЭЭШ-д бэлтгэж буй багш, сурагчдад дэмжлэг болох, үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах зорилгоор "Би Үндэсний бичигтэн" аян 3 сарын турш 6 бүлэг сэдвийн хүрээнд 12 удаагийн сорилыг авч, анализ хийн дүнг нэгтгэсэн. Тус сорил шалгалтад тогтмол 150-160 сурагч хамрагдаж байсан. Монгол хэл, бичгийн багш нарын онолын мэдлэг, мэргэжил арга зүйн захиалгат сургалтыг МУБИС-ийн Монгол судлалын сургуультай хамтран аймаг, сумын 65 багшид, "Бийрийн бичлэг"-ийн сургалтад 15 сургуулийн Монгол хэлний 60 багш, 280 гаруй сурагч, сонирхогчид хамрагдлаа. ЕБС бүрт "Бийрийн бичлэг"-ийн дугуйлан хичээллүүлж байна. "Бичиг соёл" уралдаант удирдамжийн хүрээнд "Тэргүүний уншигч" шалгаруулах аймгийн уралдаанд 14 сумын нийт 114 сурагч оролцсон. Тэргүүний уншигч шалгаруулах улсын уралдаанд 8-9	

					<p>дүгээр ангийн сурагчдын ангилалд Тэргүүн байр, тусгай байруудад орсон. “БОСОО БИЧГИЙН ГАЙХАМШИГ” хичээнгүй бичлэг, уран бичлэгийн уралдаанд 440 гаруй сурагч өөрийн бүтээлээ ирүүлж, “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдрөөр үзэсгэлэн гаргалаа.</p> <p>"Үндэсний өв соёлоо түгээгч, тээгч-2022" улсын уралдаанд 8 багш, 9 бүлгийн нийт 259 сурагч амжилттай оролцож, НДЦС-ийн МХБУЗ-ын багш Б.Оюунчимэгийн бэлтгэсэн 8е ангийн 39 сурагч улсад Гутгаар байрт шалгарсан. Төрийн байгууллагын 160 гаруй архив, бичиг хэргийн ажилтнуудад цахим бичвэрийн программыг таниулах сургалт хийсэн Насан туршийн төв, түүний нэгжүүдээр монгол бичгийн 81 удаагийн сургалтаар 2385 иргэн хамрагдаж, монгол бичгийн чадвараа нэмэгдүүлсэн. Тэдний 50 орчим хувь буюу 1196 нь төрийн албан хаагчид байна. Мөн 54 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаагаар 2332 иргэнд үндэсний бичгээ сурах, өв соёлоо хамгаалах, сурталчлан түгээн дэлгэрүүлэх ажлыг хийсэн. 7 дугаар ангийн сурагчдын дунд анги массын үндэсний бичгийн уралдаанд 1125 сурагч хамрагдав.</p>	
2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ						
9	2.1. Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлнэ.	2.1.1. Боловсролын чанарыг үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025		<p>“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 онд аймгийн Засаг даргын 2021 оны "Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих тухай", "Тэргүүний багш нарын үйл ажиллагааг дэмжих тухай" ийн А628, А/631 дугаар захирамжаар Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэсэн сурагчид нь аймгийн ИТХТ-н 2021 оны 04 дүгээр сарын 01-ний 49 дүгээр тогтоолоор баталсан Болзлыг хангасан 12 багшид 10,4 сая төгрөг, “Дэлхийн том хичээл, тогтвортой хөгжлийн боловсрол-2” үндэсний шилдэг хичээл шалгаруулах уралдаанд улсад нэгдүгээр байр эзэлсэн 3 багш 1 сая төгрөг, улс аймгийн уралдаан олимпиадад амжилт гаргасан 20 багшид 5,8 сая төгрөгийн урамшуулал, Хөгжмийн боловсролын багш нарын мэргэлийн дээшлүүлэх сургалтад 6 сая төг нийт 23,4 сая төгрөг зарцуулсан 2022 онд аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд “Чадварлаг багш” арга хэмжээний хөтөлбөрийг тусгаж,</p>	

					<p>аймгийн Засаг даргын захирамжаар элсэлтийн ерөнхий шалгалтын болзол хангасан 11 багшид 17,5, 8 сурагчид 7,8 сая төгрөг, аймаг, сумын Засаг дарга, ИТХ-ын даргын нэрэмжит сорилд 16,5 төгрөг нийт 41,8 сая төгрөг нийт 65,2 төгрөг зарцууллаа. 2022 онд боловсролын салбарын төсвийн шинэчлэлт хийгдэж Ерөнхий боловсролын сургуульд 223.1 сая, Хүүхдийн цэцэрлэгт 45.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж багш нарыг чадваржуулах сургалтад хамруулсан. Боловсролын үнэлгээний төвөөс багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж 317 багшид буюу нийт багш нарын 34.5 хувьд 10-25 хувийн нэмэгдэл олгогдсон нь багшийн цалин хөлсийг нэмэгдүүлэх нэг зорилт хэрэгжиж эхлээд байна</p>	
10	2.1.2. Тусгай хэрэгцээт боловсролын анги, бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, багшлах боловсон хүчнийг бэлтгэн, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ.	2021 - 2025		<p>Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээнд хамрагдвал зохих хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2020-2022 онд ЕБС-д 105, цэцэрлэгт 46, Насан туршийн боловсролын үйлчилгээнд 52, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжүүлэх төв”-д 25 сурч 228 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Энэ нь аймгийн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 46.5 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах, ээлтэй орчин бүрдүүлэх арга зүй олгох, түгээн дэлгэрүүлэх, хүүхдийн эрхийг хангах өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж 2020-2022 онд 345 багш, нийгмийн ажилтныг сургаж чадваржуулсан. НҮБ-ын сангаас хэрэгжүүлсэн “Тэгш оролцоот сургууль” төсөл Баянхонгор сумын Номгон, Эрдэм сургууль, Галуут, Заг, Өлзийт, Бөмбөгөр Еерөнхий боловсролын сургууль дээр хэрэгжиж “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв” -ийг сургууль бүрд 25-59 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгуулсан нь боловсролд тэгш хамруулах боломжийг олгосон.</p>		
11	2.1.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг	2021 - 2025		<p>Төрийн болон төрийн бус өмчийн 43 цэцэрлэгт 2022-2023 оны хичээлийн жилийн байдлаар 2- 5 насны 7348 хүүхэд сурч байгаа нь нийт хамрагдвал зохих хүүхдийн 85.7 хувь хамрагдаж 2020 оныхоос 4.7 хувиар өссөн байна. Боловсрол, шинжлэх ухааны сайд аймгийн</p>		

		нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ.			Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу “Эрдэнэт” үйлдвэрийн санхүүжилтээр 2021-2022 онд Бөмбөгөр, Баянбулаг, Заг сумын цэцэрлэгт, НҮБ-ын Хүүхдийн сангийн “Ус, ариун цэврийн хангамж, эрүүл ахуй” төсөл, орон нутгийн хөгжлийн сан, дэлхийн зөн олон улсын байгууллагын хөрөнгөөр Баян-өндөр, Галуут, Богд, Баянцагаан, Жинст сумын цэцэрлэгт ариун цэврийн байгууламж барьж, Баянхонгор 5 дугаар цэцэрлэгт ариун цэврийн байгууламжийн тохижилтыг зохих стандартын дагуу хийсэн нь хүүхдийн сурч боловсрох ээлтэй нөхцөлийг бүрдүүлээд байна. Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баянговь 140.0 сая, Баянхонгор сумын IY цэцэрлэг (170.0 сая) хийж гүйцэтгэсэн. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдах ажилтан багш, туслах багш, тогооч нарыг мэргэжил ур чадварыг дээшлүүлэх менежментийн сургалтын жил зохион байгуулж 55 удирдах ажилтан арга зүйч, 250 гаруй багш, 220 тус багшийг 2-3 удаагийн сургалтаар мэргэжлийг дээшлүүлсэн. Мөн 2022 онд Сургуулийн өмнөх боловсролын багш нарт сэтгэл зүйн мэдлэг олгох сэтгэлзүйн тусламж зөвлөгөө өгөх ур чадвар олгох чадваржуулах сургалтыг “Отгон тэнгэр” их сургуультай хамтран зохион байгуулж 40 багшийг бэлтгэсэн нь хүүхдийн цэцэрлэгт сэтгэл зүйч ажиллах бэлтгэлийг хангаж багш, эцэг, эх, асран хамгаалагч, хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
12		2.1.4. Сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, барилгын стандарт, норм нормативыг мөрдүүлж, эрүүл,	2021 - 2025		Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсэд, 640 хүүхдийн суудалтай сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, Баянхонгор сумын “Номгон” ахлах сургуулийн 440 хүүхдийн өргөтгөлийн барилга, Баянхонгор сумын 5 дугаар сургуулийн 960 хүүхдийн суудалтай хичээлийн барилга ашиглалтад орж Гурванбулаг сумын 160 хүүхдийн суудалтай хичээлийн байрны барилгын ажил 80 хувь, Шаргалжуут тосгоны 240 хүүхдийн суудалтай хичээлийн байрны ажил 50 хувьтай баригдаж байна. Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар Эрдэнэт үйлдвэрийн санхүүжилтээр Бөмбөгөр сумын сургууль, цэцэрлэг, Заг сумын сургууль, цэцэрлэг, дотуур байр, Баянбулаг сумын цэцэрлэг, Баян-Өндөр сумын сургууль, дотуур байр, НҮБ-ын	

		аюулгүй орчин бүрдүүлнэ.			хүүхдийн сан, Олон улсын хамтын ажиллагааны Койка байгууллага, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Баян-өндөр, Галуут сумын цэцэрлэг, Гурванбулаг сумын сургуулийн дотуур байр, Хүрээмарал сумын хичээлийн болон дотуур байр, стандартын ариун цэврийн байгууламжтай болж орчин нөхцөл сайжирч нүхэн жорлонг халсан. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Богд, Бууцагаан, Жаргалант Баян-овоо сумын сургуулийн хичээлийн болон дотуур байр, хоол үйлдвэрлэлийн заалны их засвар, Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг нийт 620 сая төгрөгөөр, Японы "Өвсний үндэс төслийн санхүүжилтээр Эрдэнэцогт сумын сургуулийн дотуур байрны барилга их засвар хийж ашиглалтад 100 хувь оруулснаар сурагчдын сурч боловсрох таатай орчин, багш нарын ажиллах нөхцөл сайжирсан.	
13		2.1.5. Сургуулийн дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль бүрт "Үдийн хоол" олгох боломжийг бүрдүүлнэ.	2021 - 2025		Ерөнхий боловсролын 25 сургуулийн 29 дотуур байранд амьдрах хүсэлтээ өгсөн 1809 хүүхэд бүрэн хамрагдаж дотуур байрны хангалт 100 хувь, стандартын шаардлага хангасан дотуур байрны гал тогоо 26, Багийн 2 сургуулиас бусад сургууль спортын заалтай, харин 9 сургууль буюу нийт сургуулийн 34 хувь нь урлагийн заалтай байна. Баянхонгор аймаг 2021-2022 оны хичээлийн жилд 1-5-р ангийн 9849, 2022-2023 оны хичээлийн жилд 9675 сурагч хамрагдаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд 6-9 дүгээр ангийн сурагчид 6577 нэмэгдэж нийт 16002 хүүхэд хамрагдахаар үндэсний хөтөлбөрт тусгагдсан боловч 2023 -2024 оны хичээлийн жилд төсөвт суугдаагүй байна. 2023-2024 оны хичээлийн жилд 6-9 дүгээр ангийн 6577 нэмэгдэж нийт 16002 хүүхдэд үдийн хоолоор үйлчлэхээр тусгагдсан 2023-2024 оны хичээлийн жилд 6577 нэмэгдэж нийт 16002 хүүхдэд хоолоор үйлчилнэ. Үдийн хоолны үйлдвэрлэл үйлчилгээний салбарт нийт 225 ажилтан ажиллаж байгаагаас ахлах тогооч -104, Туслах тогооч – 64, Гал тогооны туслах ажилтан -51 ажиллаж байна. Хүүхдийн хоол үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа тогооч нарыг чадваржуулах сургалтыг НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр цэцэрлэг, сургуулийн 109 тогоочийг хамруулж Шим судлалын төвийн баг, ШУТИС-ийн хоол үйлдвэрлэлийн багш доктор профессорууд болон	

					<p>аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгууллаа. Үдийн хоол хөтөлбөрийг аймгийн хэмжээнд 33 сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байгаа зориулалтын хоол үйлдвэрлэлийн заалгүй улмаас тендерийн гал тогоогоор хоол үйлдвэрлэлээ гүйцэтгүүлж байгаа 2 сургууль байна. Хамгийн өндөр ачаалалтай сургууль өдөрт нэг ээлждээ 672 сурагчийн хоол бэлтгэн хүргэх ажлыг зохион байгуулж байна. Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Богд, Бөмбөгөр, Заг, Галуут сумын сургууль, Баянхонгор сумын Эрдэм 4-р сургууль, Согоо сейко сургууль зориулалтын гал тогоо байхгүй цаашид өргөтгөл барих, тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай байна.</p>	
14	2.1.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, цахим сургалтыг хөгжүүлж, иргэдийн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ.	2021 - 2025		<p>Аймгийн Засаг даргын 2021 оны А/533 дугаар захирамжаар Насан туршийн боловсролын төвийг шинэчлэн байгуулж бүтэц орон тоо 15 хүний бүрэлдэхүүнтэй баталсан боловч 2021-2022 онд 8 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. 2022-2023 онд “Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж аймгийн хэмжээний баг бүрээс 2-5 өрхийг сонгон авч тухайн өрхийн боловсрол, эрүүл мэнд, амьдрах аюулгүй орчин, нийгмийн халамж, хамгаалал, нийгмийн даатгал зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн" Нэг нэгж нэг брэнд" ажил, захиалгат сургалтыг зохион байгуулж, 2021 онд давхардсан тоогоор 25600, 2022 онд 43270 иргэнд амьдрах ухаан, гэр бүл, эдийн засаг, эрх зүй, гоо зүй, ёс зүй, шинжлэх ухааны боловсрол гэсэн үндсэн агуулгаар 886 удаагийн сургалтаар, 460 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаагаар 30485 иргэнд боловсролын үйлчилгээг үзүүлсэн. Боловсролын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 65 хувь нь эмэгтэй, 49 хувь нь хүүхэд, 25.3 хувь нь төрийн албан хаагч, 8.1 хувь нь малчин, 10.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 5 хувь нь ажилгүй, 2.4 хувь нь тэтгэврийн насны иргэд байна. Иргэдийг зөв хандлага, зөв үйлд уриалсан 543 үзүүлэн, 229 шторк, 290 видео бичлэгийг гарган орон нутгийн цахим сүлжээгээр олон нийтэд хүргэн тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн боловсролын үйлчилгээг үзүүлсэн. Насан туршийн боловсролын нэгжүүд “Уран бичлэг”, “Үсчин”, “Гоо сайхан”,</p>		

					“Уран уншигч” зэрэг 10 гаруй дугуйланг хичээллүүлсэн. Монгол банк, арилжааны банкнууд, ЕБС, Эрүүл мэндийн төв, ХХҮГ, ЭМГ, ГБХЗХГ, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг 20 гаруй төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж салбар хоорондын уялдааг хангасан. Төсөв санхүүгийн хувьд хангалтгүй, өөрийн гэсэн байргүй үйл ажиллагаа явуулж байна.	
15	2.1.7. Орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжлийн боловсон хүчнийг үе шаттайгаар сургаж, Политехникийн коллежид төмөр замын чиглэлээр мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангана.	2021 - 2025			Политехник коллежид 2021-2022 оны хичээлийн жилд 18 мэргэжлээр 42 бүлгийн 848 суралцагч мэргэжлийн боловсрол эзэмшиж байна. Үүнээс 2021 онд 339 суралцагч мэргэжлийн боловсрол эзэмшиж төгссөнөөс 208 буюу 58% нь ажлын байраар хангагдсан. Төмөр замын анги нээхээр сургалтын анги танхимыг бэлтгэн элсэгчдийг бүртгэсэн боловч хичээллэх хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоож сургалт зохион байгуулагдаагүй болно. Үндсэн сургалтуудаас гадна богино хугацааны түр сургалтыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран иргэдэд мэргэжил олгох 14-21 хоногийн түр сургалтуудыг тогооч, үсчин, барилгын засал чимэглэлчин, барилгын өрөг угсрагч, автомашины засварчин, оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлүүдээр зохион байгуулсан, Өлзийт МСҮТ нь хүнсний ногоо 80, сүү, сүүн бүтээгдэхүүн 80, ойжуулалт 134 нийт 294 хүнд мэргэжил олгож байна.	
16	2.1.8. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, сургууль орчны нэвтрэлт бүртгэлийн	2021 - 2025			ЕБС-ийн 426 багш Google apps хэрэгслүүд, powtoon, socrative, skype, voov, worldwide, arduino, plickers, bandicam, camtasia, зэрэг сургалтын программуудыг ашиглаж сургалт зохион байгуулах чадвартай болсон. Сургалтаар багш нар хэрхэн classroom үүсгэж, google meet-тэй холбох аргачлалыг танилцуулж, сургалтын явцад мэдсэн зүйлээ ашиглаж анги үүсгэх түүнийгээ баталгаажуулж даалгавар илгээх үйл ажиллагааг хийж гүйцэтгэх чадвар эзэмшсэн. Мөн “Цахим сурах бичгийн онол арга зүй” сэдэвт сургалт явуулж “Цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх онол зүй сургалтын агуулга модулийг боловсруулан classroom үүсгэж багш нарыг нэгтгэн, googlemeeting ашиглан 91 багшийг хамруулан цахимаар сургалт явуулах бэлтгэлийг	

		системийг шинээр нэвтрүүлнэ.			хангасан. ЕБС, хүүхдийн цэцэрлэг Боловсролын мэдээллийн систем ESIS.edu.mn бүртгэлийн системийг ашиглаж байна. Багш нарыг зөөврийн компьютероор хангах тендерт SUMMET ХХК шалгарч гэрээ байгуулан 600 компьютерыг дагалдах хэрэгслийн хамт ЕБС, хүүхдийн цэцэрлэгүүдэд хуваарилсан. Галуут, Эрдэнэцогт, Богд, Баянхонгор сумын 5 дугаар сургуульд бичил лабораторитой болсон. Мөн аймгийн хэмжээнд цахим ангитай болгох хүрээнд ЕБС-ийн 31 сургуульд нийт 963.5 сая төгрөгийн санхүүжилтийг сургууль тус бүрд хүүхдийн тооноос хамаарч хуваарилалт хийлсэн. “Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих, хоцрогдолд өртсөн сурагчдын сурах орчин нөхцөлийг сайжруулах, багш нарын дижитал арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтын орчин цагийн танхимыг бий болгох зорилгоор “Дижитал танхим” хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж Баянхонгор сумын “Номгон”, “Эрдэнэмандал”, “Эрдэм”, Соого сейкео ерөнхий боловсролын сургуулиуд, Бууцагаан, Бөмбөгөр, Өлзийт, Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуульд иж бүрэн мэдээллийн технологийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлж сургалтын танхим байгуулсан.	
17	2.2. Аймгийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.	2.2.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах	2021 - 2025		2021 онд нийт 846 иргэнд уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлсэнээс 29,6 хувь нь Нэгдсэн эмнэлгээр, 70,4 хувь нь хувийн хэвшлийн эмнэлгээр эмчлүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах тусламж үйлчилгээнд 4962 иргэн хамрагдсан. Сум өрхийн эрүүл мэндийн төвүүд 70 хувь нь уламжлалтын их эмчээр хангагдсан. Нотолгоонд суурилсан оношилгоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, Комьпютер томографийн аппаратыг байршуулах өрөөг 5,5 сая төгрөгөөр засварлаж, ЭМЯ-ны 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Компьютер томографын аппаратаар хангаж хүний нөөцийг сургаж бэлтгэсэн. Ингэснээр иргэд орон нутагтаа өндөр нарийн мэргэжлийн оношилгоо шинжилгээнд хамрагдах боломж бүрдсэн. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд уламжлалт, сэргээн засах эмчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, анхан шатны нэгжүүдэд кабинет байгуулан иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлсэн. 2022 онд	

		боломжийг бүрдүүлнэ.			уламжлалт сэргээн засах эмчилгээнд 4145 иргэн, хэвтэн эмчлүүлэх тасгаар 503 иргэн бариа засал, зүү төөнүүр, бумба, цахилгаан зүү зэрэг 18 нэр төрлийн тусламж үйлчилгээнд хамрагдсан. Уламжлалт сэргээн засах эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн хангалт 85 хувьтай, эмч сувилагч мэргэжилтний хүрэлцээ хангамж 70 хувьтай. Цахилгаан зүү, улитра зивук, цахилгаан бумба, цахилгаан төөнүүр, имфра улаан туяа, массажны сандал зэрэг шинэ эмчилгээний төрлүүдийг нэмэгдүүлсэн. Цаашид Нэгдсэн эмнэлэгт хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэнэ. Нэгдсэн эмнэлэг нь ЭМЯ-ны 136.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар уушгины эмгэгийн оношилгоо эмчилгээний дурангаар хангагдсан. Уушги судлалаар дээшлүүлэх курст НЭ-ийн 1 эмчийг мэргэшүүлсэн, 2023 оны хичээлийн жилд уушгины дурангийн эмчээр бэлтгэнэ. Нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лабораторид 2022 оны байдлаар томуугийн вирусийн болон PCR шинжилгээнд 2200 хүн орж, орон нутагтаа оношилгоо, эмчилгээнд хамрагдсан байна.	
18		2.2.2. Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, "Эрүүл чийрэг эр	2021 - 2025		Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд сургалтыг 2020 онд Хүрээмарал, Галуут, Эрдэнэцогт сумдын иргэдэд зохион байгуулсан. Тээврийн жолооч 180 гаруй хүнд БЗДХ, ХДХВ/ДОХ-ын чиглэлээр сургалт явуулж, үзлэг зохион байгуулан, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. 2021 онд Эрэгтэйчүүдийн эмчийг бэлтгэх, сургах чиглэлээр эрүүл мэндийн хөгжлийн төвд санал хүргүүлсэн. Эрэгтэйчүүдийн кабинетед шаардлагатай тоног төхөөрөмжийн хүсэлтийг ЭМЯ-нд хүргүүлж, тоног төхөөрөмжөөр хангагдсан. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэхээр боловсруулан, аймгийн Засаг даргын 2022 оны А/703 дугаар захирамжаар батлуулж, хэрэгжилт 80 хувьтай. Төлөвлөгөөний хүрээнд эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, төрийн байгууллагууд болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 282 эрэгтэй багш ажилчид хамрагдсан. Оролцогчдын сургалтын өмнөх мэдлэг 20 хувь, дараах мэдлэг 70 хувь болж, хорт зуршлаас татгалзах, хавдраас сэргийлэх, зөв хооллох талаар мэдлэгээ нэмэгдүүлсэн. Аймгийн хүн амын дундаж наслалт 71.28	

		хүн" арга хэмжээг хэрэгжүүлнэ.			байна. Үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 68.17, эмэгтэйчүүдийнх 73.21 байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээс 5.04-өөр бага байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 9678 эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн эрсдэлийн дагуу зөвлөгөө, мэдээллээр хангаж, тусламж үйлчилгээ үзүүлсэн. ЭМС-ын 2022 оны А/449 дүгээр тушаалаар эрэгтэйчүүдэд тусламж үйлчилгээ үзүүлэх кабинетыг аймгийн НЭ-ийн амбулаторид байгуулж, 20 хүнд урологийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж, орны хүлээгдлийг бууруулсан. Эрэгтэйчүүдийн эмчийг 2022 онд урологийн мэргэжлээр сургасан, 2022-2023 оны хичээлийн жилд мэс заслын мэргэжлийн 1 эмчийг андрологийн чиглэлээр сургаж байна. 2023 оноос эрэгтэйчүүдийн төрөлжсөн тусламж үйлчилгээний кабинетыг өргөжүүлэн ажиллана.	
19		2.3.3. Иргэдийн дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулж, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж,	2021 - 2025		Хонгорчууд халдварт өвчний эсрэг хамтдаа аяны хүрээнд 2020 онд 15-55 насны иргэдийг халдварт болон халдварт бус өвчний үзлэг шинжилгээнд хамруулах удирдамж гаргасан. Энэ хүрээнд Шинэжинст, Богд сумын 2515 иргэнд үзлэг зохион байгуулж, 269,3 сая төгрөг зарцуулж, үзлэгийн хамралт 89,9 хувьтай. Дох тэмбүүгийн үзлэг шинжилгээнд 18532 хүн хамруулж, тэмбүүгийн сорил эерэг 1302 буюу 171 баталгаажсан илрүүлсэн хавьтал 112, нийт 131 тохиолдлыг 100 хувь эмчлэн эрүүлжүүлсэн. 2021 онд Коронавируст халдварын 5 давалгаа гарч, халдварын нийт 17593 тохиолдол бүртгэгдэж, 38 нас баралт гарсан. Цар тахлын үед эрүүл мэндийн байгууллага өндөржүүлсэн бэлэн байдалд ажилласан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт 34,7 хувь байсан нь цар тахалтай холбоотой үзлэгийн хамралт буурсан боловч урьд оноос 9,5 хувиар нэмэгдсэн. Аймгийн нийт хүн ам 89975 байгаагаас хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлд тулгуурлан урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог “Эрүүл жаргалтай Баянхонгорчууд”, “Малчдын эрүүл мэндийг дэмжих”, “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалаар батлагдсан Бүх нийтийн эрт илрүүлэг үзлэг, Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг, Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын аян,	

		сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулж, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.			“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний оношилгоо зэрэг 8 төрлөөр зохион байгуулж, 70379 иргэн буюу хүн амын 78.2 хувийг хамруулсан. Дээрх үзлэгүүдээс 11057 өвчлөл илрүүлж, анхан болон хоёрдогч шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээгээр 60 хувийг эрүүлжүүлсэн. Эрүүл мэндийн цогц үзлэг зохион байгуулах тухай ЭМГ-ын даргын 2022 оны А/18 дугаар тушаалаар аймгийн хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварын чиглэлээр үзлэг, шинжилгээг зохион байгуулсан. БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамрагдсан 5528 тохиолдлоос 653 өвчлөлийг шинээр илрүүлж, хавьтлын хамт 883 иргэнийг эмчилгээнд 100 хувь хамруулан зөвлөгөө өгч ажилласан. 2021 оны мөн үед БЗДХ-ын тохиолдлын тоо 845 байсан бол 2022 онд 794 болж, 51 тохиолдлоор буурсан. Сүүлийн 2 жилд төрөлхийн тэмбүү өвчин бүртгэгдээгүй.	
20		2.2.4. Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж эх, хүүхдийн эндэгдэл, үр хөндөлтийг бууруулах зорилгоор “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025		2020 онд Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй. Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 8,7 урд оноос 4,1 промилоор буурсан. Үр хөндөлтийн тохиолдол 311 урьд оноос 96 тохиолдлоор буурсан. 2021 онд Эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдсэн /100.000 амьд төрөлтөд 53,8/ Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 8,6 урд оноос 0,1 промилоор буурсан. Үр хөндөлтийн тохиолдол 166 урьд оноос 145 тохиолдлоор буурсан. Нөхөн үржихүйн насны 24569 эмэгтэйчүүдэд 20 сум, 4 өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн зөвлөгөө өгөх 2 кабинетаар дамжуулан НҮЭМ, гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллийг хүргэж, үйл ажиллагааг тогтмолжуулан ажилласан. 2022 онд давхардсан тоогоор 9380 хүн НҮЭМ-ийн гэр бүл төлөвлөлт, охидын жирэмслэлт, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх сэдэвт сургалтыг танхим болон цахим хэлбэрээр хүргэж ажилласан. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөнд 15 ажил тусгагдсанаас хэрэгжилт 78.0 хувьтай. Аймгийн хэмжээнд 2022 онд 1665 эх төрж, өнгөрсөн оны мөн үеэс 179 төрөлтөөр буурсан. Нийт төрсөн эхийн 94.6 хувь нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 5.16 хувь нь сумын эмнэлэгт төрсөн байна. Тайлангийн жилд эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдол бүртгэгдэж, 2 эхийн амь нас аврагдсан бол	

					эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 59.6 байна. Аймгийн хэмжээнд 0-1 насны 16 хүүхэд эндэж, нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 9.5 промилл байна. Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 56,2 хувь нь аймгийн төвд эндэж, хүйсээр авч үзвэл 50,0 хувь нь эрэгтэй хүүхэд байна. Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 37.5 хувь нь нярайн эрт үедээ, 37.5 хувь нь нярайн хожуу үедээ, 25.0 хувь нь 29 хоногтойгоос 1 хүртэлх насандаа эндсэн байна. 1 насны 16 хүүхэд эндэж, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 эндэж 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдлийн түвшин 12.6 промилл болж өнгөрсөн оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.	
21	2.2.5. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана.	2021 - 2025		Анхан шатны эмнэлгүүдэд 2020 онд Улсын төсвийн хөрөнгөөр 2,9 тэрбум төгрөг, Орон нутгийн төсвөөс 243.0 сая төгрөг, Олон улсын байгууллага төсөл хөтөлбөрөөр 1,3 тэрбум, хандив тусламжаар нийт 73,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, нэн шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан. 2021 онд ДЭМБ-ын санхүүжилтээр Бөмбөгөр, Баянцагаан сумын ЭМТ-үүд, мобайл технологийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 244.6 сая төгрөгийн санхүүжилтээр 16 сум, 4 өрх ЭМТ-үүд мобайл технологи мөн 555.4 сая төгрөгний өртөгтэй амьсгалын аппарат, түргэн тусламжийн машины яаралтай тусламжийн багц багаж тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Аймгийн ИТХ-ын 2021 оны 6/23 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд Улсын төсвийн 208.0 сая төгрөгийн санхүүжилтээр анхан шатны 12 сум, өрхийн эрүүл мэндийн төвийг гематологийн болон биохимийн бүрэн автомат анализатороор /цусны дэлгэрэнгүй, элэгний үйл ажиллагааны шинжилгээ/ хангасан. Ингэснээр анхан шатны нэгжүүдийн лабораторийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэлт 68 хувьтай хийгдэж, үр дүнд нь хөдөөгийн иргэдийн оношилгоо шинжилгээний хүлээгдэл чирэгдэл буурсан. Улсын төсвийн 137.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 сумдын 33 багийн эмчийг мотоциклоор хангасан. Мотоцикл эвдэрсэн, бүрэн		

					<p>зогссон зэрэг Эрүүл мэндийн газрын хэрэгцээний судалгаан дээр үндэслэн багийн эмч нарыг унаажуулсан. Багийн эмч нарыг унаажуулснаар алслагдсан нутаг дэвсгэрт амьдарч байгаа хөдөөгийн иргэдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэн, жирэмсэн эх, 0-5 насны хүүхэд, хэвтрийн эмгэгтэй, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хяналт, гэрийн эргэлт хийх зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p>	
22	2.2.6. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		<p>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага нь 2020 онд улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сан, үндсэн үйл ажиллагааны орлогын эх үүсвэрээс 9,1 тэрбум төгрөгний санхүүжилтээр иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд орон нутгийн төсөв тусгай зориулалтын шилжүүлэг, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрээс 9,7 тэрбум төгрөгний санхүүжилтээр тусламж үйлчилгээ үзүүлсэн. 2021 оноос Эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэн. Гүйцэтгэлийн санхүүжилтээр лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага нийт 10 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна. Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоол, Өрх, сум, тосгоны ЭМТ-ийн төсвийн төслийг ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоол, нэг иргэнд ногдох төсвийг төлөвлөхдөө 2021 оны жилийн эцсийн ҮСГ-ын тайлагнасан хүн амын тоонд үндэслэн шинээр төрсөн болон нас баралтын зөрүүгээр цэвэр өсөлтийг тооцож зардлыг төсөвлөсөн. ЭМД-ын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх хэсэгт заасан өрх, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх ТҮ-ний тоо хэмжээг ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолын дагуу тухайн сум, орон нутгийн хүн амын эрэлт, хэрэгцээнд үндэслэн тооцоолж төсвийг төлөвлөж гүйцэтгэлээр 25,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ЭМД-ын сангаас авч салбарын хэмжээнд өргүй ажилласан. НЭ-ийн эмч ажиллагсдын цалинг 20-40 хувиар нэмэгдүүлсэн төдийгүй өөрийн урсгал зардлын төсвөөс тасаг нэгжүүдэд 1.4 тэрбум төгрөгийн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Манай аймгийн эрүүл мэндийн байгууллагууд тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 2022 онд ЭМДС-</p>		

					аас нийт 37.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. Үүнийг шатлал бүрээр задалж үзвэл Нэгдсэн эмнэлэг 13.6 тэрбум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 2.1 тэрбум, сумдын ЭМТ 16.6 тэрбум, хувийн эмнэлгүүд 1.9 тэрбум, сувилал 1.7 тэрбум, эмийн сангууд 1.7 тэрбумын санхүүжилтийг авсан. Энэ нь өмнөх жилээс 29 хувь өссөн.	
23		2.2.7. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	2021 - 2025		Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн зэрэг хувь 2020-2021 онд 73,0-91,0 хувьтай. Эмнэлгийн мэргэжилтнүүдтэй холбоотой алдаа зөрчил бүртгэгдээгүй. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, ёс зүйтэй хамт олон 6 аяныг өрнүүлэн үр дүнг тооцсон. Эрүүл мэндийн салбарын 126 нэгж байгууллагад нийт 1300 гаруй эмнэлгийн мэргэжилтэн бусад ажиллагсад ажиллаж байна. Үүнээс их эмч 194 буюу 16 хувь, сувилагч, тусгай мэргэжилтэн 536 буюу 44.5 хувийг эзэлж байна. Эмч сувилагчийн харьцаа 1:1.4 байна. Одоогоор шүдний эмч, тархвар судлаач, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, дотор, дотоод шүүрэл, үе мөч судлал (ревматологи) ахмадын эмч, багийн эмч дутагдалтай байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/336 дугаар захирамжаар 2022 оны Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10.0 сая төгрөг зарцуулан, эрүүл мэндийн удирдлага, хүний нөөцийн магистр, сувилахуй зэрэг 4 чиглэлээр 12 мэргэжилтнийг сургасан. 2022 онд давхардсан тоогоор эрүүл мэндийн байгууллагуудын 1700 гаруй эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн 98 чиглэлээр ажлын байрны сургалтад хамрагдаж чадавхажсан. 2022 оны төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр бөөрний мэс засал судлал, эх барих эмэгтэйчүүдийн эхо, дурангийн онош зүй, жирэмсний хяналт, сэргээн засахын сувилахуй, хавдрын сувилахуй, хүүхдийн сувилахуй, эрчимт эмчилгээний сувилахуй зэрэг чиглэлээр анхан болон хоёрдогч шатлалын эмнэлгийн 18 эмч, сувилагч нар суралцаж, эрүүл мэндийн салбарын нэн шаардлагатай мэргэжлээр хүний нөөц бэлтгэгдэж байна. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/578 дугаар тушаалын дагуу үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг эрүүл мэндийн 24 нэгж байгууллага улирал тутам авч, өөрийн байгууллагыг	

					үнэлсэн дүнгээр нийт 6920 хүн хамрагдсанаас сэтгэл ханамжийн эерэг хувь 91.2 хувьтай үнэлэгдсэн.	
24		2.2.8. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэнэ.	2021 - 2025		Нэгдсэн эмнэлгийн 9.4 тэрбум төгрөгийн өртөгтэй Амбулаторийн шинэ барилгын ажлыг "Рокпэинт групп" ХХК 2021 оноос эхлэн гэрээ байгуулж гүйцэтгэн, барилгын суурь болон каркас угсралт бүрэн хийгдэж дууссаж, өрлөгийн ажлыг эхлүүлж гүйцэтгэл 50 хувьтай байна. Уг барилга ашиглалтад орсноор аймгийн 89.000 гаруй хүн амд хоёрдогч шатлалын өндөр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанар, стандартын шаардлагад нийцсэн ая тухтай орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэнэ. Оточномгон өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын ажлын гүйцэтгэгчээр "Базардарь" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Нийт 827.752.000 төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдсэн. Тус өрхийн эмнэлэг ашиглалтад орсноор 7300 гаруй хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ээлтэй орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэж, аймагтаа өрөө тасалгааны хүртээмжтэй, стандартад нийцсэн жишиг өрхийн эмнэлэгтэй болно. Улсын комисс хүлээж авахаар ажиллаж байна. Галуут сумын эрүүл мэндийн төвийн халдвартын эмнэлгийн 356.0 сая төгрөгийн засварын ажлын тендерт "Ар жаргалантын гол" ХХК шалгарч гэрээ байгуулан, 2022 онд орсон 100.0 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэл бүрэн хийгдсэн. 2023 онд үлдэгдэл 256.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Эрдэнэцогт сумын 1.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий жишиг эрүүл мэндийн төвийн барилгын гүйцэтгэгчээр "Рино Инженеринг ХХК" гэрээ байгуулан, каркасын ажил бүрэн дууссан, эмнэлгийн 2 давхар болон эмчийн байр, моргийн барилгын өрлөг хийгдэж, дулааны шугам татагдсан. Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүрээмарал сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Зураан Даваа ХХК"-тай гэрээ байгуулан, төмөр бетон хийцлэлийн ажил хийгдэж, дээвэр, барилгын гадна, дотор заслын ажил хийгдэж байна. Заг сумын эрүүл мэндийн төвийн 87.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дээврийн засварын ажлын	

					тендерт “Жаргантайн хөх тариа” ХХК шалгарч, барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай, улсын комисс хүлээж авсан.	
25		2.2.9. Эм, эмнэлэгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумдын эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгоно.	2021 - 2025		Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар 20 сумын эмийн санд тусгай зөвшөөрөл олгож, ЭМГ, сумын ИТХ, сумын ЭМТ, эмийн сангуудтай дөрвөлсөн гэрээ байгуулан, сумдын эмийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, нэг үнийн нэгдсэн бодлогыг бий болгож, хяналт тавин ажилласан. Сумдын эмийн санг аж ахуйн тооцоот үйл ажиллагаанд шилжүүлэн, Эрүүл мэндийн газар, сумын ИТХ, Эрүүл мэндийн төв, Эмийн сангийн хооронд хамтран ажиллах дөрвөлсөн гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд Эрүүл мэндийн газраас хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 85.0 хувьтай байна. Эмийн сангуудын өрсөлдөх чадварыг бий болгох, эм зүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эмийн үнийн бодлогыг зохицуулах үүднээс 2021-2022 онд 3 сумын эмийн санд тусгай зөвшөөрөл олгоод байна. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа Наянбулаганга, Арвижих-Эрдэнэ тун, Лхам, Баруун-Шанд, Монгол Эм импекс зэрэг 8 эмийн санд удирдамжийн дагуу үнэлгээ хийж MNS 5260:2015 стандартын хэрэгжилт, антибиотик эмийг жороор олгож байгаа эсэх, ил тод байдал, эмийн үнийн тариф зэрэг үйл ажиллагааг хянаж, зөвлөн туслах үйлчилгээг хүргэн ажилласан. Сумдын 20 эмийн сангийн эмийн үнийн зөрүүнд судалгаа хийж, дүгнэлт гаргахад тухайн эмийг үйлдвэрлэсэн улс болгоны эмийн үнэ харилцан адилгүй байдаг тул алслагдсан суманд 20-30 хувийн нэмэгдэлтэй, ойрын суманд 10-20 хувийн нэмэгдэлтэйгээр эм зүйн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Сумдын эмийн сангуудтай байгуулсан 2022 оны гэрээний хэрэгжилт 90 хувьтай байна. Аймгийн хэмжээнд нийт 45 эмийн сан ажиллаж байгаа бөгөөд 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулсан байна.	

26		2.2.10. Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулах (Үзлэгийн цаг захиалга, эмчийн үзлэг, өвчтөний цахим карт, лабораторийн хариуг цахимаар авах үйл ажиллагаа)	2021 - 2025		<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Цахим эрүүл мэнд” төслийн санхүүжилтаар 2020 онд серверийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн бөгөөд программ хангамж дээр ажиллах ажилчдыг үе шаттайгаар сургалтад хамруулан, программыг туршилтаар ашиглаж эхэлсэн. Эрүүл мэндийн салбарын нэгдсэн цаг захиалгын төвийн callpro үйлчилгээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн 7044-2549 дугаарыг холбуулж, цахим цаг захиалгын үйлчилгээг үзүүлдэг болсон. 2021 оноос Нэгдсэн эмнэлэгт E-Health программ хангамж, серверийн тоног төхөөрөмжийн суурилуулалт 100 хувь хийгдэж дууссан. Тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах ажлын хүрээнд нийт 57 ширхэг суурин компьютер, принтер, хурууны хээ уншигч, бар кодны машинуудыг худалдан авч, хэвийн үйл ажиллагаагаар хангагдсан. 2022 оны байдлаар Нэгдсэн эмнэлгийн 180 эмч, ажилтан 12 модуль, 460 гаруй функцийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Цахим бүртгэл, Амбулаторийн үзлэг, Лабораторийн шинжилгээ, Түргэн тусламж, Яаралтай тусламж, Дүрс оношилгоо, Цус цусан бүтээгдэхүүн захиалга, зарлага, Стационарын тусламж үйлчилгээ, Хэвтүүлэх захиалга, Цахим өвчний түүх, Эм эмнэлгийн туслах материал захиалга зарлага, Иргэний эрүүл мэндийн цахим дэвтэр зэрэг нийт 12 төрлийн үйлчилгээг цахимжуулан ажиллаж байна. Тухайн иргэн цаасан карт авч явах шаардлагагүй болж, эмчид үзүүлсэн тэмдэглэл, оношилгоо шинжилгээний хариу гэх мэт өвчний бүх түүх цахим хэлбэрээр хадгалагдаж байна. Аймгийн эрүүл мэндийн E-Health программ ашигладаг бүх шатлалын эмнэлгүүдэд тухайн иргэн үзүүлэхэд өвчний цахим түүхийг нэгдсэн баазаас харах боломжийг 100 хувь бүрдүүлсэн.</p>	
27	2.3. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого	2.3.1. Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт	2021 - 2025		<p>“Хонгорын гэр бүл” арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж АЗДТГ-ын Удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн Засаг даргын А/265 тоот захирамжаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Захирамжийн хэрэгжилтийг хангах арга зүйн зөвлөгөөг албан байгууллага, сумдын холбогдох мэргэжилтэнүүдэд өгч сум, байгууллагууд үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж эхлээд байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр бүлийн боловсрол олгох</p>	

	хэрэгжүүлж, хүний хөгжил, хамгааллыг сайжруулна.	тохирсон байдлаар олгоно.				8 модуль сургалтыг 1869 хүнд үе шаттайгаар зохион байгуулж 59 сургагч багш бэлтгэсэн. Архины хамааралтай иргэнийг “Жаргалтай амьдрал төв”-д холбон зуучлах, хүүхдийн “Өвгөнжаргалант” зусланд “Аз жаргалтай гэр бүл” хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж хэвшсэн.	
28		2.3.2. Хуримын ордныг ашиглалтад оруулж, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулна.	2021 - 2025			Барилга ашиглалтад ороогүй тул үйл ажиллагаа эхлээгүй. Хүний нөөцийг бэлтгэж, сургалтын модуль боловсруулсан.	
29		2.3.3. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025			Аймгийн Засаг даргын 2022 оны А/196 дугаар захирамжаар Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. 20 сумд салбар зөвлөл байгуулагдсан. Зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг жил бүр зохион байгуулж Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг 90 хувийн хэрэгжилттэй амжилттай хэрэгжүүлсэн. Сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, гэр бүлийн тоо, хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, гэр бүлийн тоо, хамтарсан багийн үйлчилгээний бүртгэл зэрэг 5 үзүүлэлтээр мэдээллийн сан бүрдүүлэн улирал тутам шинэчлэн ажиллаж байна. - Хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан насанд хүрэгчид - 18,451, хүүхэд - 8869, - Сэтгэлзүйн зөвлөгөө авсан хүүхэд насанд хүрэгчид – 286 - Хосын зөвлөгөөнд хамрагдсан гэр бүл - 19 байна.	
30		2.3.4. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн	2021 - 2025			Ковид цар тахлын улмаас хөдөлмөр зуслан ажиллуулаагүй. Өвгөнжаргалант зуслангийн хөгжлийн хөтөлбөрт	

		зуслангийн жишигт нийцүүлж, сум бүрт хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана.			хамрагдсан 338 хүүхдэд малчин айлыг түшиглэсэн сургалтыг зохион байгуулсан.	
31		2.3.5. Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ.	2021 - 2025		“Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг 2017-2022 онд амжилттай хэрэгжүүлсэн.Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/264 дүгээр захирамжаар “Хүүхдэд ээлтэй орон нутаг” санаачилгын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
32		2.3.6. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна.	2021 - 2025		“Эх нутаг өв соёлоо эрхэмлэн дээдэлж угийн бичгийг өрх бүр хөтлөх аян”-ыг 3 сарын хугацаатай зарласан. Аяны хүрээнд 3178 иргэдэд угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг зохион байгуулж гарын авлага тараасан. Шинээр угийн бичгээ хөтөлж эхэлсэн өрхүүдэд зөвлөн туслах ажлыг 20 сумд зохион байгуулж 115 өрх шинээр угийн бичгээ хөтөлсөн. Аймгийн хэмжээнд угийн бичиг хөтлөлтийн программыг нэвтрүүлж 20 сум, 10 багт хүлээлгэн өгөх, “Уг, удам судлах танхим”-ын нээлтийн үйл ажиллагаа, Үндэсний төв архивын газарт хадгалагдаж буй 1957 оноос хойших хүн амын тооллогын баримтыг цахимаар архивын тасагт төвлөрүүлэх зэрэг ажлууд зохион	

					байгуулагдлаа.Аймгийн Засаг даргын А/542 дугаар захирамжаар Аймгийн төрийн архивын дэргэд Ураг удмаа судлах танхим байгуулж, “Угийн бичиг” хөтлөхөд ашиглах программыг нэвтрүүлэх, аймгийн төрийн архивын тасагт бүрдсэн хүн амын тооллогын баримтуудад түшиглэн иргэдийг архивын лавлагаа мэдээллээр ханган уншлагын танхимаар үйлчлэх боломжийг бий болгож шаардлагатай мэдээлэл лавлах материалын сан бүрдүүлэн ажиллаж байна. Угийн бичиг хөтлөлт 10.2 хувьтай болж 7 хувиар өссөн.	
33	2.4. Орон нутгийн хөгжилд инновац шингэсэн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	2.4.1. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан "Судалгааны баг" байгуулж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		Монгол Улсын Засгийн газраас шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт анхаарал хандуулж “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод суурилан “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2019 оны 379, “Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 299 дүгээр тогтоолуудыг үндэслэн тус зөвлөлөөс “Аймгийн шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийг дараагийн хурлаар батлуулахаар болсон. Баянхонгор аймгийн салбар бүрээс төрөн гарсан эрдэмтэн мэргэдийн судалгаа мэдээлэлд тулгуурлан, мэргэдийн чуулганыг зохион байгуулан Баянхонгор аймгийн хөгжлийн бодлогод шинжлэх ухаанч, мэдлэгт суурилсан төлөвлөлтийг тусгах, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах зорилт тавьж ажиллаж байна. Баянхонгор аймгийн шинжлэх ухаан инноваци, технологийн салбар зөвлөл нь хөдөө аж ахуй, хөдөлмөр халамж, соёл боловсрол шинжлэх ухаан, аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүдийн төлөөлөл 11 хүний бүрэлдэхүүнтэй. Худалдаа Үйлдвэрлэлийн Их сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургууль байгуулагдсаны 20 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан “Бидний манлайлал, ногоон хөгжил” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. Үүнд Баянхонгор сумын Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Польштехникийн коллежийн багш, сурагчдын нийт 42 илтгэл эхний шалгаруулалтад оролцов. Хоёрдугаар шатанд шалгарсан насанд	

					хүрэгчдийн 12, сурагчдын 10 орлолцогчид илтгэлээ танилцуулан 1-3 байрын эзэд тус тус тодров.	
34		2.4.2. Эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.	2021 - 2025		Манай орны говийн бүсийн ХАА-ын онцлог, нөхөн сэргээгдэх нөөц баялгаа ашиглан цөм технологи бий болгохыг МУ бодлогоор дэмжиж кластер хэлбэрээр хөгжүүлэх, ингэний хатаасан сүүний эрэлт нэмэгдэж буй өнөөгийн цаг үед экспортлох нь малчид, орон нутаг цаашлаад улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой Ингэний хатаасан сүү үйлдвэрлэж дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх. Говийн тэмээ бүхий аймгууд тэмээн сүргийн зөв бүтцийг бий болгох, ашиг шимийг хүртэх нөхцөлийг хангах, түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хүнсний үйлдвэрлэлээс гадна үйлдвэрийн хэрэгцээг дагаж эрчимжсэн аж ахуй хөгжих, газар тариалан хөгжих, тэмээний ноосны үйлдвэрлэл бий болох, тэмээний мах /борцны үйлдвэрлэл худалдаа нэмэгдэх, тээврийн салбарт ажил үйлчилгээ нэмэгдэх зэргээр салбар дундын олон ажлын байр бий болж, хүн амын ажлын байр нэмэгдэх онцлогтой. Ингэний сүү сүүн бүтээгдэхүүнийг ахуйн хэрэглээнд маш ихээр хэрэглэж байгаа хэдий ч ISO шаардлага хангасан боловсруулах үйлдвэр, бүтээгдэхүүн төдийлөн олон биш байна. Сүүний онцлог, эрүүл мэндийн ач холбогдол зэргээр Шинжлэх ухааны судалгаа хийгдсэн байна. 2021 онд Монгол улс Ингэний хатаасан сүүний стандартыг боловсруулж баталгаажуулсан нь шинэлэг байлаа. МУ-ын хэмжээнд хэд хэдэн ижил үйлдвэр баригдаж байна. Ингэний хатаасан сүү үйлдвэрлэж хүнс амын хүнсний хэрэглээнд нэвтрүүлэх, эхийн сүү орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эрүүл мэндийн ач холбогдолтой хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Тухайн технологийг нутагшуулах, хөгжүүлэхэд шаардагдах хугацаа 3 -10 жил байна. Орон нутгийн хэмжээнд боловсруулах үйлдвэр нэгийг барьж дуусаад байна. Харин түүхий эд бэлтгэн нийлүүлэх хагас эрчимжсэн аж ахуйг Баянхонгор аймгийн говийн сумдад 40 ширхэг байгуулахаар төлөвлөж байна. Үүний дүнд хөдөөд ажлын байр нэмэгдэх, газар	

					нутгаа зохистой ашиглах, газар тариалан хөгжүүлэх гээд санхүүгийн болон хүний нөөцийн үр өгөөж нэмэгдэх юм	
35	2.5. Иргэдэд ээлтэй, аюулгүй амьдрах, баталгаат орчныг бий болгоно.	2.5.1. Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлж хүнсний аюулгүй байдлыг хангана.	2021 - 2025		Зах зээлд худалдаалж буй бараа бүтээгдэхүүний чанар хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах ажил үйлчилгээг эрчимтэй явуулах үүднээс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын үүрэг чиглэлийн дагуу хэрэглээний эрэлт, нийлүүлэлтийн нийцтэй байдлыг хангуулахад 115 худалдааны, 5 хүнсний үйлдвэр, 60 хүнсний тээвэрлэлт, 4 хүнсний түгээлтийн үйл ажиллагаанд д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 5 нэр төрлийн зөвлөмж боловсруулан тарааж, хадгалалтын горим алдагдсан 19 нэр төрлийн 310300 төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг устгаж, чанар аюулгүй байдалд онцгой анхааран ажилласан. Аймгийн хэмжээнд хүнс үйлдвэрлэл болон хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт жилд 2 удаа ээлжит болон давтан баталгаажуулалт хийж ажилладаг ба баталгаажуулалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгах арга хэмжээ авч, холбогдох стандартаар зөвлөмж хүргүүлж ажилласан. 2022 оны жилийн эцсийн дүнгээр говь, хангайн сумдууд болон аймгийн төвийн нийт 273 худалдаа үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж 262 газарт тохирлын гэрчилгээ олгож хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.	
36		2.5.2. Ахмад настанд зориулсан “Хөгжлийн төв”-ийг барьж, сум суурин газарт ахмадын нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэнэ.	2021 - 2025		Аймгийн хэмжээнд 13 сум ахмад настны өргөө, танхимыг байгуулж, үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. Ахмад настны асрамж үйлчилгээний төвөөр 10 асруулагч үйлчлүүлж, асруулж байна. 2022 онд 179.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 11 дүгээр сарын 30-ны байдлаар 148.162.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Ахмадын тэтгэвэрт 105 ахмад настан хамрагдаж 309.6 сая төгрөг, Алдар цолтой хөнгөлөлт, тусламжид 29 ахмад хамрагдаж 4.8 сая төгрөг, Насны хишиг тэтгэмжид 3825 ахмад хамрагдаж 641.4 сая төгрөг, Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтөд 3929 ахмад настанд 366.2 сая төгрөг, Ахмад настны зөвлөгөө өгөх үйлчилгээнд 146 ахмад зөвлөгөө авч 9.9 сая төгрөг, Явуулын үйлчилгээнд 71 ахмад хамрагдаж 12.0 сая төгрөг. Ахмадын өдрийн	

					үйлчилгээнд 138 ахмад хамрагдаж 9.9 сая төгрөг, Сэргээн засах үйлчилгээнд 166 ахмад хамрагдаж 33.3 сая төгрөг, нийт 8409 ахмад настанд 1.387.1 сая төгрөгийн үйлчилгээг үзүүлсэн байна.	
37	2.5.3. Нийт хүн амын амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай, зам бүхий эрүүл аюулгүй тохилог орчныг бүрдүүлнэ.	2021 - 2025			Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амрах, спортоор хичээллэх зориулалт бүхий "Оготной булаг" спорт цогцолборыг байгуулсан. Тус спорт цогцолбор нь: - Сагсан бөмбөгийн талбай - Волейболын талбай - Хүүхдийн тоглоомын талбай - Крикетийн талбай - Крикетийн талбайг тойрсон 1,2 км дугуйн зам - Задгай талбай, сүүдрэвч - 198м урт гэрэлт гудамж - Ариун цэврийн байгууламж - Хойд болон баруун талд 100 гаруй автомашины зогсоолтойгоор барьж байгуулан иргэдийн эрүүл аюулгүй тохилог орчныг бүрдүүлсэн. Мөн Улсын төсвийн 11,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Усан бассейн бүхий спорт цогцолборын барилгыг барьж 2022 оны 12 дугаар сард байнгын ашиглалтад оруулсан. Ингэснээр 1000 гаруй хүний багтаамж бүхий спортын бүх төрлийн арга хэмжээ зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлээд байна.	
38	2.5.4. Аймгийн ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2021 - 2025			Аймгийн хэмжээнд нийт 6414 иргэн, 537 аж ахуйн нэгж байгууллага 264940 ширхэг модыг шинээр тарьж 892.346.600 төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: 1429 айл өрх 18247 ширхэг мод, бичил цэцэрлэг саад хүрээлэнд 30903 ширхэг мод, 60.8 га талбайд шинээр нэрэмжит ой төгөл байгуулан 12268 ширхэг мод, 37.45 га талбайд шинээр 9 бичил цэцэрлэг хүрээлэн 11695 ширхэг мод, 72.7 га талбайд зүлэгжүүлэн, 22 га талбайд цэцгийн мандал, төв суурин газарт 34.7 га талбайд 71784 ширхэг мод, хамгаалалтын ойн зурвасын 106.6 га талбайд 369245 ширхэг мод, ойжуулалтад 121.7 га талбайд 39064 ширхэг модыг тус тус тарьсан. Нийт ногоон байгууламжийн хэмжээг 456 га талбайгаар нэмэгдүүлж өмнөх оноос 4 дахин их модыг шинээр тарьж, амьдралтын хувийг 70.8 хувьд хүргэсэн байна.	
39	2.5.5. Агаар, хөрс, усны бохирдлыг үе шаттайгаар	2021 - 2025			Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр НҮБ-ын "Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ" төсөл, "Утаагүй	

		бууруулах арга хэмжээ авч ажиллах, иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллана.			Баянхонгор" төслийг орон нутаг хамтран хэрэгжүүлсэн. "Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ" төслөөс энэ онд 3 сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн өргөтгөл, 2 цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар, өргөтгөл, 2 эрүүл мэндийн төвийн засвар, өргөтгөл, 1- ундны усны гүний худаг, 1-ундны усны худгийн цэвэршүүлэх төхөөрөмж, 3-нийтийн ариун цэврийн байгууламж, 1-халуун усны тохижилт нийт 14 ус хангамж, ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлж, хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр ажилласан. Мөн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн 12 удаагийн танхимын болон цахим сургалтыг зохион байгуулж 7438 иргэнийг хамруулсан байна. "Утаагүй Баянхонгор" төслийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран энэ онд аймгийн зорилтот бүлгийн 130 өрхөд өрхийн дулаан алдалтыг багасгах ЧИП багцыг олгосон. 2019-2022 онд Баянхонгор аймгийн төвийн гэр хорооллын 602 айлыг Халаалт, дулаалгын ЧИП багцад хамруулсан бөгөөд нийт 602 өрхийн 40 хувь нь бага насны хүүхэдтэй, 38 хувь нь ахмад настан, 17 хувь нь өрх толгойлсон эцэг эх, 5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус тус эзэлж байна. Төсөлд хамрагдсан өрхийг нүүрс түлдэг өрхүүдтэй харьцуулсан судалгаанаас харахад тухайн өрхийн гишүүдийн амьсгалын замын өвчлөл 30 хувь буурсан сайн үзүүлэлттэй байна.	
3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА						
40	3.1. Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж	3.1.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралаа авч явах дадал, хэвшлийг	2021 - 2025		Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 2021 онд “Цар тахалын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” зэрэг 5 хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийт 1301 хүнд 555,7 сая төгрөг зарцуулсан. Үүнээс байнгын болон түр ажлын байранд нийт 1243 иргэн зуучлагдсан. 2022 онд “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй	

	давхаргыг нэмэгдүүлнэ.	дээшлүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна.			эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” зэрэг 7 хөтөлбөр арга хэмжээнд давхардсан тоогоор 4200 иргэн хамрагдаж 1.9 тэрбум төгрөг зарцуулсан. Хөтөлбөрүүдийн үр дүнд байнгын ажлын байр 463, түр ажлын байр 1714 бий болсон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо өмнөх оноос 30.9 хувиар өсч, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 29.2 хувиар нэмэгдсэн.	
41		3.1.2. Нийгмийн хамгаалалын үйлчилгээнд хамрагдагсдаас зохион байгуулалаттай ажлын байраар хангах үйлчилгээгээр дамжуулан тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа иргэдийн судалгаагаар хөдөлмөрийн насны 1100 иргэн байгаагаас ажил идэвхтэй хайгч 609 иргэн байна. Дээрх иргэдээс байнгын ажлын байранд 28 иргэн, аймгийн бүтээн байгуулалтын ажил буюу мод тарих, явган замын өнгөт хавтан суурилуулах, хог хаягдал ангилан ялгах, цэвэрлэх, улирлын чанартай түр ажлын байранд 300 иргэнийг тус тус зуучилж, ажлын байраар хангасан. Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 220, аж ахуй эрхлэлт, төсөл хөтөлбөрийн сургалтад 50, амьдралын итгэл үнэмшил олгох, хөдөлмөрт бэлтгэх, авьяасыг нь дэмжих бүлэг үүсгэх сургалтад 160, өдөрлөг яармаг, бусад арга хэмжээнд 349, 779 иргэнийг хамруулж чадавхжууллаа. Нийгмийн халамжийн сангийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 2021 онд 6 бүлгийн 14 гишүүнийг 8.7 сая төгрөгийн, 2022 онд 4 бүлгийн 8 гишүүнийг 6.9 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэгт хамруулж, түр ажлын байраар хангасан. Дээрх арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 1136 иргэн хамрагдсан.	
42		3.1.3. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын	2021 - 2025		Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа. Гэрээний хэрэгжилтийн дундаж 9.6 хувьтай байна. Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч мөн	

	үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана.			ажил хөдөлмөр эрхэлдэггүй 12188 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд, 0-3 настай хүүхдээ асарч буй эх 1409 иргэний сайн дурын гэрээг байгуулж, шимтгэлийг санд төлүүлсэн. Даатгалд хамрагдсан 13597 даатгуулагчийн хамрагдалтыг ажил хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр авч үзвэл малчид 6759, хувиараа хөдөлмөр эрхлэгч 1826, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 1253, оюутан 21, бусад 2329, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 1409 байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон тодорхой хөдөлмөр эрхэлдэггүй иргэд 5826, малчин 12273, оюутан 1373, нийт 19472 даатгуулагч эрүүл мэндийн заавал даатгалд хамрагдсан нь нийт /40860 хүн/ хамруулбал зохих иргэдийн 47.6 хувь байна. Шинээр сайн дурын нийгмийн даатгалд даатгуулагчдын хувь өмнөх онуудаас 2.9 хувиар, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагч 3950 хүнээр буюу 5.1 хувиар тус тус өссөн байна.	
43	3.1.4. Жендэр ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ.	2021 - 2025		Жендэрийн салбар хороог аймгийн Засаг даргын 2021 оны А/618 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж гишүүдийг чадавхжуулах сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж хэвшсэн.20 сумд Жендэрийн дэд салбар хороог байгуулж жендэрийн мэдрэмжтэй төрийн албыг хөгжүүлэх, төрийн албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг жил бүр зохион байгуулж байна. Төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага боловсруулж сургагч багш нар бэлтгэсэн.Бага наснаас нь хүний эрх жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг өгөх зорилгоор Жендэрийн салбар хороо, ГХУСАЗСЗөвлөл хамтран "Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид орчинг дэмжих нь" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлж 15 сургагч багш бэлтгэн сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг түшиглэн 4-5 настай хүүхдүүдийг хамруулан амжилттай хэрэгжүүлж байна. Үндэсний хорооны цахим сургалтад удирдлагуудыг хамруулах арга хэмжээг нэгдсэн журмаар зохион байгуулж байна.	
44	3.1.5. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд	2021 - 2025		Өрх толгойлсон эцэг, эхчүүд болон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 130 иргэнийг байнгын, 287 иргэнийг түр ажлын байранд зуучилсан. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн	

		амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өрх толгойлсон эцэг, эхчүүд, 40-өөс дээш насныхан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.			хүрээнд 40-өөс дээш насны 80 иргэнд 390.0 сая төгрөгийн, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 52 ахмад настанд 158.0 сая төгрөгийн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 55 хөгжийн бэрхшээлтэй иргэнд 196.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн.	
45		3.1.6. Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар хуримтлалтай болгох арга зүйд сургаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай болгон “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025		Жил бүр Дэлхийн хуримтлалын болон мөнгөний өдрийг тэмдэглэн өнгөрүүлж хэвшсэн бөгөөд 2021 онд 46 удаагийн 46 танхимын болон онлайн сургалтыг зохион байгуулж, 479 сурагч шинээр хуримтлал үүсгэж, 218 харилцагч цахим бүтээгдэхүүнд холбуулан, сурагчдад зориулсан банкуудын картыг 160 сурагчид шинээр авч байсан бол 2022 онд аяны хүрээнд 620 орчим сурагчдын дунд цахим сургалт зохион байгуулж, 100 орчим хүүхэд 22.5 сая төгрөгийн хадгаламж шинээр үүсгэсэн байна. Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах, дунд ангийн “Жижиг мөнгөн тэмдэгтийг хэн сайн цуглуулах вэ” уралдааныг 1 сарын хугацаанд зарласан нийт Баянхонгор аймаг болон 19 сумдаас 60 орчим хүүхэд багачууд цуглуулсан жижиг дэвсгэртээ тушааж нийтдээ 63,000 орчим ширхэг жижиг мөнгөн дэвсгэртийг банкуудад тушааж оролцсон байна. Дэлхийн мөнгөний 7 хоног аян явагдсан хугацаанд аймгийн банкуудын харилцах 2.6 тэрбум төгрөгөөр өссөн нь иргэд, байгууллагын санхүүгийн боловсрол дээшилсэн төдийгүй банкинд хадгалуулах, хуримтлуулах хандлагатай байгааг илтгэж байна.	

46	3.2.. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.	3.2.1. Төр, хувийн хэвшлийн оролцоотой “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021 - 2025		Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжүүлэх боломжтой газрын байршлын судалгааг БХБЯам, ТӨСК хүргүүлсэн. 2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд санал хүргүүлсэн боловч тусгагдаагүй болно. Гэвч аймаг орон нутаг инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд “Шинэ суурьшлын бүс”-ийн инженерийн шугам сүлжээний ажил болон Баянхонгор хотын дулааны 2-р хэлхээний шугам сүлжээний ажлыг эхлүүлэх, Баянхонгор сумын 4 багийн 1066, 5 дугаар багийн 1270 гэр хорооллын нийт 2000 гаруй айлуудыг цэвэр, дулааны шугам сүлжээнд холбох ажлыг цогцоор нь шийдвэрлэж дэд бүтцийг сайжруулан ажиллаж байна. Мөн “Залуус” амины орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, амины орон сууцны хорооллыг бий болгох ажлыг зохион байгуулан 2023 онд улсын төсвийн 27 тэрбум төгрөгөөр гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн системд үе шаттайгаар холбох ажлыг эхлүүлээд байна. Эдгээр ажлууд үе шаттай хийгдсэнээр орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэн, агаар хөрсний бохирдол тодорхой түвшинд буурна.	
47		3.2.2. Аймаг, сум суурин газруудад төлөвлөлтийн дагуу хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц барих төслийг бодлогоор дэмжинэ.	2021 - 2025		Хувийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 267 айлын 9 орон сууцны барилга байнгын ашиглалтад орсон бөгөөд 2022 онд 1124 айлын 24 орон сууцны барилгын угсралтын ажлыг эхлүүлж тухайн онд 262 айлын 8 орон сууцны барилгад улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулаад байна.	
48	3.3. Эрүүл, идэвхитэй амьдралын хэв	3.3.1. Спорт цогцолбор бүхий усан бассейныг	2021 - 2025		Усан бассейн бүхийн спорт цогцолборын барилгыг улсын төсвийн 11.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж 2022 оны 12 сард хүлээж авсан Олон улсын уралдааны стандартын таван замтай усан	

	маягийг сурталчлах, эрүүл аж төрөх ёс, нийтийн биеийн тамирыг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн түвшинд	ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.			бассейн, спортын дөрвөн заал, оффисын 16 өрөө тасалгаатай, спортын олон төрлөөр хичээллэх, бэлтгэл хийх танхим бүхий томоохон бүтээн байгуулалт бий болсноор нийтийн биеийн тамир хөгжих, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчин бүрдсэн. Улс, бүсийн чанартай Клубүүдийн аварга шалгаруулах волейболын тэмцээн, Спорт бүжгийн хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээн, Монголын Хүүхдийн спортын зуны 7 дугаар наадмын анхан шатны 10 төрөлт тэмцээнийг тус тус зохион байгуулаад байна	
49	дэмжин хөгжүүлнэ.	3.3.2. Иргэдэд эрүүл зөв хооллолт, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдараа хөгжүүлэх спорт, спортын дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг эрүүл, зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж, эерэг хандлагатай болгох нөлөөллийн үйл ажиллагааг бодлогоор дэмжин, төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлж,	2021 - 2025		Аймгийн Засаг даргын нэрэмжит дасгал хөдөлгөөн хийцгээе аянд сумд болон төрийн албан хаагч, иргэд 860 хүн, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нэрэмжит “Цахим гимнастрада” арга хэмжээг 4 төрлөөр зохион байгуулж 57 багийн 552 иргэд хамрагдсан нийтийн биеийн тамирын арга хэмжээнүүдийг зохион байгуулж улсын хэмжээнд Дэд байрт шалгарсан. - Аймгийн хэмжээнд "Эрүүл иргэн - Эртэч Баянхонгорчууд" аяныг зохион байгуулж, 36 спорт заал, 2 чийрэгжүүлэх танхим, 16 соёлын төвийн үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус 73 байгууллага, 13 сумын 36547 хүн, Багийн иргэдийн дунд “Нэг баг-Нэг өрх” спортын 3-н төрөлт тэмцээн зохион байгуулж 540 тамирчин, -“Ахмадын биеийн тамирыг дэмжих сар” аяныг тохиолдуулан Баянхонгор сумын 9 багийн дунд явган аялал, софт волейбол, дасгал хөдөлгөөн, гранд гольф, олс таталт зэрэг спортын арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 680 гаруй ахмад хамрагдсан үйл ажиллагааг зохион байгуулсан	

		“Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ.					
50		3.3.3. Аймаг, сум, багт үйл ажиллагаа явуулж байгаа спорт заалнуудыг ашиглалтыг сайжруулж, нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг хөгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	2021 - 2025			Баянхонгор аймгийн хэмжээнд 47 спорт заал тогтмол үйл ажиллагаа явуулж сумдад биеийн тамирын арга зүйч ажиллаж байна. Биеийн тамир спортын газрын харьяа 7 спорт зааланд 7 хоногийн 2 өдрийг иргэдийг биеийн тамир спортоор хичээллэх, 5 өдөрт албан байгууллагуудад, хүүхэд залуучуудад өдрийн цагаар спортоор хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зохицуулалт хийсэн. Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгсэд давхардсан тоогоор 41046, Уралдаан тэмцээнд оролцогчид 8860, төлбөртэй үйлчилгээ авсан иргэд 6854, ахмад настан 6146, секц дугуйлан, сургалтад 438 хүүхэд хамрагдаж нийт 63344 хүн нийтийн биеийн тамираар хичээллэж байгаа нь өмнөх оноос 8.7 хувиар өссөн үзүүлэлтэй байна.	
51	3.4. Орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	3.4.1. Орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	2021 - 2025			Аймгийн газар зохион байгуулалтын үндсэн баримт бичиг болох аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн хөгжлийн сангийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 2021-2022 онд “Ланрес” ХХК боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Тайлант онд Баянлиг, Жинст, Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан, Баацагаан сумууд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Тайлант онд Баянбулаг, Богд Бөмбөгөр, Эрдэнэцогт сумууд нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг хийлгэж байгаа бөгөөд Баянбулаг, Богд сумууд багийн иргэдийн нийтийн хурлаараа хэлэлцүүлэн сумын ИТХ-аараа хэлэлцүүлэн батлуулж хүлээн авлаа. Бөмбөгөр, Эрдэнэцогт сумууд зөвлөх үйлчилгээний тендэрийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.	

4. ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

52	4.1. Төсвийг орон нутгийн хөгжлийн бодлоготой	4.1.1. Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах замаар төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх	2021 - 2025		Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын дагуу орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан иргэдийн саналд үндэслэн Монгол улсын Засгийн газар Сангийн яамнаас хэрэгжүүлж буй иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх бодлогыг чиглэл болгон төлөвлөлтийг хийж Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлэн УИХ-аар батлагдсан төсвийг Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж 2021,2022 оны төсвүүдэд зохицуулалт хийж өр авлага үүсгэлгүй ажилласан.	
53	уялдуулан төлөвлөж, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангана.	4.1.2. Иргэд олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ.	2021 - 2025		1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад татварын талаарх ойлголт, мэдээлэл хүргэх, эх оронч сэтгэлгээтэй, улс, орныхоо хөгжилд өөрийн төлсөн татвараар дамжуулж, хувь нэмрээ оруулдаг, шударга иргэн болж төлөвшүүлэх зорилготой Бид ирээдүйн татвар төлөгч арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж, аймгийн төвийн 5 сургуулийн 400 гаруй сурагч, 19 сумын 19 ерөнхий боловсролын сургуулийн 950 сурагчдад Татварын хэлтсээс бэлтгэсэн "Татвар гэж юу вэ", "Татвар бидний амьдралд" хичээлийг танилцуулж, татварын талаарх ойлголт, мэдээллийг хүргэлээ. 2. Татвар төлөгчдөд зориулсан сургалт, сурталчилгааны төлөвлөгөө боловсруулан батлуулж нийт танхимаар 191 удаагийн сургалтанд 4198 татвар төлөгч, Нээлттэй засаг-Нэг Баянхонгор, Баянхонгор татварын хэлтэс facebook, Баянхонгор аймгийн татварын хэлтэс цахим сувгаар нийт 430 гаруй мэдээлэл сурталчлан 25520 иргэнд түгээн ажилласан байна. 3. Олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөний дагуу 13 төрлийн сэдвээр 10210 боршур хэвлэж, 8936 иргэнд тараасан.	
54		4.1.3. Татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих	2021 - 2025		2022 онд улсын төсөвт 2.8 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 3.0 тэрбум төгрөг төвлөрүүлж 106.3 хувийн биелэлттэй буюу 175.7 сая төгрөгөөр давуулсан, орон нутгийн	

		хяналт, татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулах замаар татварын суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийг бууруулан, улс орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлнэ.			төсвийн татварын орлогоор 17.2 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 21.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, 126.7 хувийн биелэлттэй буюу 4.6 тэрбум төгрөгөөр давуулан биелүүллээ. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогоор 2022 онд нийт 20.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 24.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, 123.9 хувийн биелэлттэй буюу 4.8 тэрбум төгрөгөөр татварын орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж ажиллалаа. Улс, орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад төлөвлөгөө нь 4.1 тэрбум төгрөг, гүйцэтгэл нь 4.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 348.4 сая төгрөгөөр өссөн гүйцэтгэл нь 90.7 сая төгрөгөөр буурсан мөн орон нутгийн орлогын төлөвлөгөө 6.6 тэрбум төгрөгөөр гүйцэтгэл нь 7.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.	
55		4.1.4. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтын хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	2021 - 2025		Аймгийн газар зохион байгуулалтын үндсэн баримт бичиг болох аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн хөгжлийн сангийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 2021-2022 онд “Ланрес” ХХК боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Тайлант онд Баянлиг, Жинст, Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан, Баацагаан сумууд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Тайлант онд Баянбулаг, Богд Бөмбөгөр, Эрдэнэцогт сумууд нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг хийлгэж байгаа бөгөөд Баянбулаг, Богд сумууд багийн иргэдийн нийтийн хурлаараа хэлэлцүүлэн сумын ИТХ-аараа хэлэлцүүлэн батлуулж хүлээн авлаа. Бөмбөгөр, Эрдэнэцогт сумууд зөвлөх үйлчилгээний төндэрийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.	
56	4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж,	4.2.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, бичил уурхай	2021 - 2025		Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоол батлагдсанаар бичил уурхай эрхлэгчид хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэх боломжгүй нөхцөлд 3 жил байсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран эрдэс баялгийн салбарын хууль	

	<p>өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, орон нутгийн нөөцөд тулгуурласан хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.</p>	<p>эрхлэгчдийг дэмжиж ажиллана.</p>			<p>тогтоомжийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Хариуцлагатай уул уурхай-2022" зөвлөгөөнийг 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. Зөвлөгөөнд Баянхонгор аймгийн бичил уурхай эрхлэгчид оролцож бичил уурхайн талаарх журмын зөрүүтэй ойлголтуудыг засаж нэгдсэн ойлголтод хүрсэн. Зөвлөгөөнөөс гарсан уриалгыг аймгийн Засаг даргын албан бичгээр Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад тус тус хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 243 дугаар тогтоолоор "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам" шинэчлэгдэн батлагдаж бичил уурхай эрхлэгчид хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэх боломж бүрдсэн.</p>	
57		<p>4.2.2. Орон нутгийн түүхэн дурсгалт, үзэсгэлэнт газруудыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, нэг жуулчнаас олох орлогыг нэмэгдүүлнэ.</p>	2021 - 2025		<p>Аймгийн аялал жуулчлалын нөөц газар болох "Их Богд"-ын байгалийн цогцолборт газрын "Төрийн тахилгат Их Богд уул"-ын Цонж хайрхныг түшиглэн аялал жуулчлалын отоглох цэг байгуулсан. Энэхүү Их Богд уулын Цонж орчмыг тохижуулж отоглох цэг байгуулснаар дотоод, гадаадын жуулчдын амрах, аялах тав тухтай орчныг бүрдүүлсэн төдийгүй байгаль орчныг хамгаалж, бүс нутгийн эдийн засаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн үнэ цэнийг нэмэгдүүлсэн. Энэ онд тус аймагт 46228 дотоодын аялагч, 1271 гадаадын аялагч хүрэлцэн ирсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 3 дахин өссөн бол орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд жуулчдаас 1.862.082.752 төгрөгийн орлого орж мөн л өмнөх оноос 19 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p>	
58		<p>4.2.3. Орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүйгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хөрөнгө оруулалтын</p>	2021 - 2025		<p>Орон нутгийн нөөц, түүхий эдэд тулгуурлан нэмүү өртөг шингэсэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэл байгуулахаар Ингэний сүүний үйлдвэр, мах ногооны зоорь, малын тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлүүдийг барьж байгуулах, кластер төслүүдийг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлж ажиллаж байна. Эдгээр хөдөө аж ахуйн кластер төсөл хэрэгжиж эхэлснээр экспортод бараа бүтээгдэхүүнээ</p>	

		нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.			борлуулж, малчдын амьжиргааг хоршоолуулан дэмжиж, 2000 гаруй ажлын байр бий болох юм.	
59		4.2.4. Аймгийн эрчим хүчний ЦДАШ, дэд станцыг нэмэгдүүлж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана.	2021 - 2025		Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчээр "ДИ ЭМ ТИ ЭМ" ХХК шалгаран гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. Энэ онд төлөвлөгдсөн ажил бүрэн хийгдсэн. Мөн Байдрагийн голын усан цахилгаан станцын ТЭЗҮ-г "Мон гидро констракшн" ХХК улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр гүйцэтгэж байна. Тус төслийг 2023 оны 2 дугаар улиралд хүлээлгэн өгнө.	
60		4.2.5. Олон улсын болон орон нутгийн автозамыг нэмэгдүүлэх, босоо тэнхлэгийн зам дагуу сумдыг хатуу хучилттай автозамаар аймгийн төвтэй холбоно.	2021 - 2025		Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, Захиран зарцуулах журмыг үндэслэн 1.5 тэрбум төгрөг замын санд төвлөрүүлэн 1.2км зам дагуу явган хүний зам, аймгийн төв доторх 1800м2 талбайд нөхөөс хийх ажил, аймгийн төв доторх 1.65км авто зам, 55 машины авто зогсоол, сургууль орчмын бүсийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах ажил, аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах ажил, аймгийн төв доторх асфальтан хучилттай 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээний засвар, шинэчлэлт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	
61	4.3. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн	4.3.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, ажлын байр нэмэгдүүлэх, брэнд бүтээгдэхүүн бий болгох, малын	2021 - 2025		Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл нийт төсөвт өртөг 2.5 тэрбум 2022-2023 онд хэрэгжихээр ХХААХҮЯ-ы захиалгаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газарт нийт 3 багц ажил, арга хэмжээний тендер зарлагдсан байна. 2022 онд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр багц 1 буюу Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн зориулалттай тусгай үйлчилгээний автомашины худалдан авах тендер зарлагдаж, гүйцэтгэгчээр "Улаанбаатар ариутгал" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан. Нийт 15 тусгай зориулалтын машин нийлүүлэгдэхээс 2 машин нийлүүлэгдэж үлдэгдэл 13 нь 2023 оны 1 дүгээр улиралд ирнэ. 2023 онд багц-2 Хүнсний ногооны хүлэмж	

	<p>үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:</p>	<p>үүлдэр угсааг сайжруулах, малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих "Шинэ хөдөө" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>			<p>трактор, иж бүрдэл 1.210 сая төгрөг, багц-3 Малын зохиомол хээлтүүлгийн зөөврийн пункт, багажны иж бүрдэл, ачааны машин 290.0 сая төгрөг нийт 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилттэй ажил арга хэмжээ хүлээгдэж байна. Хөдөө аж ахуйн кластер байгуулах ажлыг 2021 оноос улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 онд хэрэгжүүлэн дуусахаар төслүүд хэрэгжиж байна. Ингэний сүүний үйлдвэрийн төслийн ажилд 4 барилгын ажил болон үйлдвэрийн барилгын тоног төхөөрөмжийн ажлууд багтсан бөгөөд эхний барилга болох Ингэний сүүний үйлдвэрийн үндсэн барилга 100 хувь баригдаж хүлээлгэн өгсөн. Барилгын ажлын гүйцэтгэгчээр "Базардарь"ХХК ажилласан. Ингэний сүүний үйлдвэрт 2021-2022 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Мах, ногооны 1000тн-ийн зоорийн барилгын ажил нь 40 хувьтай ба 2023 онд дуусгах төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна. Мах ногооны зоорь барих ажлын гүйцэтгэгчээр "Сант Өндөр" ХХК ажиллаж байна. Тус ажлын нийт санхүүжилт 3.1 тэрбум бөгөөд 2021-2022 онд 1.2 тэрбум төгрөг олгосон</p>	
62		<p>4.3.2. Орон нутгийн бичил, дунд, жижиг үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.</p>	2021 - 2025		<p>2022 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 500.0 сая төгрөгийн эх үүсвэр батлагдаж хөнгөлөлттэй зээл олгох журмын дагуу төслийг хүлээн авч 16 аж ахуйн нэгж байгууллагаас 2.2 тэрбум төгрөг хүссэн төслийг цахимаар хүлээн авсан. Зээлийн мэдээллийн сангуудад өр төлбөртэй буюу зээлийн муу түүхтэй, аж ахуйн нэгж нь төслийн материалын иж бүрдэл дутуу, хангаагүй шалтгаанаар 12 ААН хасагдаж 4 ААН-н 291.8 сая төгрөг хүссэн төслийг хэлэлцэн, баталж, төслийн жагсаалт, захирамжийн хамт ХХААХҮЯамны ЖДҮГ-т хугацаанд нь хүргүүлж санхүүжилт бүрэн олгогдсон. Орон нутгийн төсвөөс ЖДҮ-ийг дэмжих төслийг зарлаж, сонгон шалгаруулан 2022 онд нийт 44 иргэн, ААН-д 558.5 сая төгрөгийн төсөл хөтөлбөрийн санхүүжилт олгосон. Олгосон төсөл хөтөлбөрийг үйлдвэрлэлийн салбараар ангилбал хүнсний үйлдвэрлэл 15, хөнгөн үйлдвэрлэл 20, газар тариалан 6, бусад 4 гэсэн тэргүүлэх чиглэлийн дагуу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн байна. Үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ая тухтай</p>	

					<p>үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг болгож 20 асар майхан худалдан авсан. Орон нутагт аймгийн түүхт 80 жилийн ойн хүрээнд “Баянхонгорт үйлдвэрлэв”, “Намрын ногоон өдрүүд”, “Говийн чоно” олон улсын сургалт, дадлагын үеэр нийт 3 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж давхардсан тоогоор 180 гаруй иргэн, ААН оролцож 80 гаруй сая төгрөгийн борлуулалт хийж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилсан байна. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд” “Нүүдэлчин Монгол” фестивалийн үзэсгэлэн худалдаанд 10 иргэн, ААН бүтээгдэхүүнээ сурталчлан оролцсон.</p>	
63	4.3.3. Шинэ санаа, оюуны бүтээл, судалгаа шинжилгээнд тулгуурласан брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2021 - 2025		<p>Орон нутгийн түүхий эд, нөөц боломжид тулгуурлан судалгаа хийгдэж, төсөл боловсруулж ХАА-н кластер байгуулагдахаар төлөвлөгдсөн. Тус ажлын хүрээнд Ингэний сүүний үйлдвэрлэл байгуулж, бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингээн гадаад зах зээлд гаргах, мах ногооны зоорь байгуулах ажлыг эхлүүлээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2024 онд бүрэн хэрэгжиж дуусна.</p>		
64	4.3.4. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан санхүүжилтын шинэ хэлбэрийг нэвтрүүлж, бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж ур чадварыг хөгжүүлэн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		<p>Орон нутгийн төсвөөс ЖДҮ-ийг дэмжих төслийг зарлаж сонгон шалгаруулан 2022 онд нийт 44 иргэн, ААН-д 558.500.000 төгрөгийн санхүүжилт олгосон. Төсөл хөтөлбөрийг үйлдвэрлэлийн салбараар ангилбал хүнсний үйлдвэрлэл 15, хөнгөн үйлдвэрлэл 20, газар тариалан 6, бусад 4 гэсэн тэргүүлэх чиглэлийн дагуу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн байна. ЖДБизнес эрхлэгчдийг дэмжихээр 2017 оноос хойш Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК байгуулан орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж ирсэн. 2017-2022 онд нийт 177 иргэн, ААН-д 3 тэрбум төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, бизнес инкубаторын төвөөр 100 гаруй гарааны бизнес эрхлэгчид бойжсон байна. Мөн хоршоо хөгжүүлэх сангаас 14 сум зээл олгож 56 хоршоодыг дэмжин 1.9 тэрбум төгрөгийн зээл олгон дэмжин ажиллаж байна.</p>		

65		4.2.5. Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барьж ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар "Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" тогтоолын 2-р хавсралт хөрөнгө оруулалтын хөтөлбөр, санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтад "Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих техникийн шинэчлэл хийх төсөл" Баянхонгор аймагт 2021-2025 онд хэрэгжихээр батлагдаж хүлээгдэж байна.	
5. ТАВ. ЗАСАГЛАЛ						
66	5.1. Засаглалын чанарыг дээшлүүлнэ.	5.1.1. Төрийн байгууллагуудын шударга байдлын түвшинг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор цахимаар болон танхимын сургалтыг давхардсан тоогоор 3000 гаруй албан хаагчдад зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх зөвлөгөөг MGL радиогоор 370 удаа, лед дэлгэцээр 1200 удаа, фейсбүүк хуудсаар 205 удаагийн давтамжтай давхардсан тоогоор нийт 181.800 иргэнд мэдээлэл хүргэж Үр дүнд: Авлигын гэмт хэргийн гаралтын тоо 2021 оны 4 нэгжээр буурсан 2022 онд 1 нэгжээр өссөн байна. Шударга байдлын үнэлгээгээр 2021 онд 68.8-тай, 2022 үнэлгээгээр 68.5%-тай үнэлэгдсэн Цахим хуудасны ил тод байдлын түвшин өмнөх онтой харьцуулахад 57.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
67		5.1.2. Чадварлаг ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ.	2021 - 2025		Аймгийн хэмжээнд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 425.656.490 төгрөг, ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр 224.000.000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж нийт 30 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 6120 удирдах болон гүйцэтгэх ажилтнуудад цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж албан хаагчдыг чадваржуулсан. Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлын хүрээнд "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ээр 8 байгууллагын 364 төрийн албан хаагчдад, цахимаар 20 сумын 120 байгууллагын 1800 гаруй төрийн албан хаагчдад "Удирдах ажилтны шуурхай мэдээллийн цаг"-аар 64 байгууллагын дарга нарт, давхардсан	

					<p>тоогоор 184 байгууллагын 2228 албан хаагчдад сургалт, мэдээлэл хийсэн.Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор “Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба” аяныг 2 дахь жилдээ 180 төрийн байгууллагын дунд зарлаж, 3 зорилтын хүрээнд 19 байгууллага "Чадварт тулгуурлаж, чанар хүртээмжтэй үйлчилье" шинэ санаачилгыг нэвтрүүлж хамт олноо манлайлсан албан хаагчдыг шалгаруулж, сурталчилж, 28 байгууллага албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 35 байгууллага 3 үеийн уулзалтыг зохион байгуулж, төрийн албаны залгамж чанарыг хадгалах олон нийтэд сурталчилсан, 43 байгууллага албан хаагчдынхаа санаачилгыг дэмжиж “Мэргэжил бүхэн сайхан” podcast, нэвтрүүлэг хийж олон нийтэд сурталчилж, идэвхтэй ажилласан 5 байгууллагыг алдаршуулсан. Аяныг зохион байгуулснаар: Аймгийн хэмжээнд төрийн албаны нэр хүнд дээшилж, салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдсэн.Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг сурталчлах ажлыг эрчимжүүлсэн нь "Төрийн албаны шинэтгэлийн" бодлогыг хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болсон.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлын тоо 33 хувиар буурсан зэрэг үр дүн гарсан.</p>
68	5.1.3. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлж гурван талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ.	2021 - 2025		<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг 2016 оноос орон нутгийн болон улсын төсвийн санхүүжилтээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор дахь салбартай хамтран ажиллаж байна.Хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 36 хүүхэд, 16 насанд хүрэгч эмэгтэй байрласан. Нийт байрласан 36 хүүхдийг хүйсээр нь ангилвал үүнээс 18 эрэгтэй, 18 эмэгтэй хүүхэд байна. Үйлчлүүлэгчид дунджаар 10-35 хоногийн хугацаатай байрласан. ГБХЗХГ-аас Түр хамгаалах байрны ажилтан албан хаагчдыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна.</p>	

69	5.2. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн шуурхай үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	5.2.1. Аймгийн хэмжээнд бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлэн, багтаамжийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025			Баянхонгор аймгийн сумдын сүлжээгүй алслагдсан нутаг дэвсгэрт 2021,2022 онуудад үүрэн холбооны оператор компанийн сүлжээг 15 цэгт шинээр байгуулж үүнээс “Нийтийн үүргийн сангийн хөрөнгөөр 4 цэгийн байгуулсан. Аймгийн хэмжээнд 20 сум, агентлаг байгууллага, албан ёсны цахим хуудсыг ашиглаж, аймгийн https://bayanhongor.gov.mn/ цахим сайтад холбогдож, сум орон нутаг, байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, иргэд олон нийтэд аймаг орон нутгийн бодлого шийдвэрийг цахим хэлбэрээр хүргэж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан.	
70		5.2.2. Цахим засаглалын тогтолцоонд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, дэд бүтэц, инновац нэвтрүүлэх замаар төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	2021 - 2025			Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи инновац нэвтрүүлэн дараах үр дүнд хүрч ажилласан. Үүнд: -Аймгийн хэмжээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системийн нэвтрүүлснээр нутгийн захиргааны байгууллагын уялдаа холбоо сайжирч, тайлангийн ирц, чанарт ахиц гарсан. -Онцгой байдлын газар Е-Монголиа системд иргэдийн өргөдөл гомдол хүсэлтийг хүлээн авч, Галын аюулгүй байдлын 14 дүгнэлтийг олгосон. -Багш нар суралцагч, багшийн, ангийн журнал, эцэг эхтэй холбох хүсэлт, хичээлийн хуваарь, гарын авлага, хүүхдийнхээ дүн үнэлгээ, гэрийн даалгавар, ирц, чөлөө, хичээлийн хуваарь, агуулга, үдийн хоолны зураг, сургалтын байгууллагын бүртгэлийг харах боломжтой. Боловсрол шинжлэх ухааны газар, цэцэрлэг сургуулиуд байгууллага, багш, сурагчдын үнэлгээг судлагдахуун, бүлэг сэдэв бүрээр www.bi.eec.mn , www.stat.eec.mn хаягаар үзэх боломжтой. -Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж e-health программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн 12 модуль, 460 гаруй функцийг ашиглаж байна. -Татварын хэлтэс бүртгэл хийх, тайлан илгээх, татвараа төлөх үйлчилгээг цахимжуулан ажиллаж байна. -Улсын бүртгэлийн хэлтэс 81 төрлийн лавлагаа үйлчилгээг цахимжуулсан, -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар барилгын үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрлийг urban.gov.mn цахим хаягаар 2022 онд 56 иргэн, аж	

					<p>ахуйн нэгж байгууллагаас хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн, - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нийгмийн халамжийн 14 төрлийн үйлчилгээг 100 хувь цахимд шилжүүлсэн, -Мал эмнэлгийн нэгдсэн системээр малчдад гарал үүслийн гэрчилгээ 8205 олгосон, - Модем, антенн цаг уурын автомат станцад байрлуулж олон нийт интернэт ашиглан liveweather хаягаар монгол улсын аль ч нутаг дэвсгэрээс цаг уурын бодит мэдээг авах, -Баянхонгор сумд багийн заалны үйлчилгээг 70442682 утсаар захиалах, QR кодоор төлбөр төлөх үйлчилгээг нэвтрүүлсэн. -Тайлант онд E-mongolia системээр 244 төрлийн үйлчилгээг 11167 хүнд хүргэж, үйлчлүүлэгчдийн тоо өмнөх оноос 34 хувиар өссөн байна.</p>	
71		<p>5.2.3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.</p>	2021 - 2025		<p>Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 21-ны өдрийн А/272 дугаар захирамжийн дагуу "Дижитал Баянхонгор" арга хэмжээ зохион байгууллаа. "Цахим шилжилтийг хүн бүрд" уриатай "Inspire 2022" арга хэмжээгээр 400 гаруй иргэд төрийн албан хаагч, 800 гаруй ЕБС-ын ахлах ангийн сурагчдыг хамарсан мэдээллийн технологийн чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан бол төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан 40 ажилтан мэргэжилтнүүдэд "Сүпер Админ" нэртэй Active director, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал сэвдийн хүрээнд 16 цагийн чадавхжуулах (24.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий) сургалтыг үнэ төлбөргүй зохион байгууллаа.Мөн УИХ-ын тамгын газар, цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академи, ХХЗХ, зэрэг яам агентлагуудтай хамран төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдэд мэдээлэл өгөх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, шинээр хэрэгжиж байгаа цахим хөгжлийн багц хуулиудыг танилцуулах, төрийн цахим үйлчилгээний нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж нийт 5000-гаруй иргэд төрийн албан хаагчдыг хамруулан ажиллалаа.Аймгийн хэмжээнд нийт 59134 иргэн тоон гарын үсэг авахаас 2022 оны хагас жилээр 5360 буюу 9,6 хувь байсан бол жилийн эцсийн байдлаар 20222 буюу 34,1 хувь болж хагас жилээс</p>	

					24,5 хувиа өссөн дүнтэй байгаа нь иргэдийн цахим ур чадвар нэмэгдэж төрийн үйлчилгээг шуурхай авах боломж бүрдсэн	
72	5.2.4. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн нийтэд ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн хяналт, оролцоог хангах системийг нэвтрүүлнэ. /жнь:тусгай зөвшөөрөл, лиценз олголтын явц, төсөв, санхүү/	2021 - 2025			Аймгийн хэмжээнд 20 сум албан ёсны сайттай болж, мэдээллийн баяжилт 60 хувьтай, Гурванбулаг, Жаргалант, Эрдэнэцогт, Бууцагаан, Баянхонгор сумдын ашиглалт хангалттай, Заг, Шинэжинст, Баян-овоо сумдын ашиглалт хангалтгүй, 25 хэлтэс, агентлаг, газар холбогдсон ба Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Статистикийн хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Татварын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Төрийн аудитын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар зэрэг нь вэб сайтаар иргэдэд мэдээ мэдээллийг хүргэж, цаг үеийн болон бусад 1500 мэдээлэл нийтлэгдэж, иргэдийн хандалтын тоо 6500 болсон байна. “Нээлттэй засаг –Нэг Баянхонгор” пэйж хуудсаар 3000 агуулга бүхий мэдээллийг боловсруулан бэлтгэж, давхардсан тоогоор 636,100 гаруй мянган иргэдэд хүргэсэн. 2022 оны 12 сарын 13-ны байдлаар тус пэйж хуудсанд 21,800 мэдээлэл байршиж байна. Аймгийн бодлого шийдвэр, хэрэгжилт, орон нутгийн цаг үе, үйл явдлын 4385 минутын 150 агуулга төрөл бүхий видео бэлтгэж түгээсэн.	
73	5.2.5. Бүс нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.	2021 - 2025			Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймгийн УТХГН-ийн Их Богдын Байгалийн цогцолборт газар буюу тус аймгийн аялал жуулчлалын томоохон нөөц газар болох Төрийн тахилгат Их Богд уулын Цонж хайрхныг түшиглэн Аялал жуулчлалын Отоглох цэг байгуулсан. Отоглох цэг нь дотоод, гадаадын жуулчдын амрах, аялах тав тухтай орчин бүрдүүлсэн төдийгүй, бүс нутгийн эдийн засгийг дэмжих, байгаль орчныг хамгаалах, ТХГН-ийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нутгийн иргэдийн оролцоо, түүнээс хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.Баянхонгор аймаг нь БНСУ-д төвтэй Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо, БНСУ-ын Кёнги муж, Ансан хотын Данвон эмнэлэг, Чамжиун эмнэлэг, Япон улсын Ойта муж, БНХАУ-ын Альшаа аймаг, Эзнээ хошуу, Нинша Хуйн хотон үндэстний	

					Өөртөө Засах Орон, ОХУ-ын Буриад улсын Кабанский муж, Франц улсын “Сиряк” ХХК, Бүгд Найрамдах Болгар улсын Русе муж, Польш улсын Веунчика хот, Австри улсын Кейртнер хот, АНУ-ын Вүүдсайт хот, Бүгд Найрамдах Унгар улсын Худалдааны Төлөөлөгчийн Газрууд зэрэг 13 хөрш зэргэлдээ гадаадын орнуудтай санамж бичиг байгуулж, гадаад харилцаагаа өргөжүүлэн хамтран ажиллаж байна.	
6. ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ						
74	6.1. Байгаль орчныг хамгаалах, байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлнэ.	6.1.1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө.	2021 - 2025		“Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслөөс Баацагаан сумын Бөөнцагаан нуурыг улсын тусгай хамгаалалтад авах талаарх хэлэлцүүлгийг аймгийн мэргэжлийн байгууллагуудын дунд зохион байгуулсан. Олгой нуур, Товцог хайрхан, Галуутын хавцлыг Байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авах хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэн, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй. Мөн Баянбулаг сумын нутагт орших Тэгш Буянт-Өндөр Өлзийт уул, Эрдэнэцогт сумдын нутагт орших Гурван Эрхтийн нуруу, Баян-Өндөр сумын нутагт орших Эдрэнгийн нуруу орчмын газар нутгийг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах саналыг холбогдох сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлснээс Гурван эрхтийн нуруу орчмын 22,575,5 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг Баян-Овоо сумын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 02/13 дугаар тогтоолоор дэмжсэн. Галуут, Баянбулаг, Баян-Өндөр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал дэмжээгүй байна.	
75		6.1.2. Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эхүүдийг судалж хамгаалах, урсацыг нэмэгдүүлэх арга	2021 - 2025		Бууцагаан, Баянлиг, Баян-Өндөр сумдын нутагт улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын судалгаа хийгдэж нөөц тогтоогдсон газрын доорх усны ордыг тэжээгдлийн мужуудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Үүнд: Бууцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар тогтоол, Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр тогтоол, Баян-өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/58	

		хэмжээ авч ажиллана.			дугаар тогтоолоор тус тус тусгай хамгаалалтад авч тогтоолуудыг Байгаль орчин аялал жуулчлалын яамны Ой, Ус Тусгай хамгаалалтай газрын кадастрын хэлтсийн мэдээллийн санд бүртгүүлсэн мөн сумдын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм мөрдүүлж ажиллаж байна. Мөн Галуут суманд 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хяналт шалгалт хийх үеэр газрын доорх усны нөөц тогтоогдсон ордын гадаад тэжээгдлийн мужид хогны карьер үүсгэсэн тул Галуут сумын Засаг даргын Тамгын газарт 2022 оны 128 дугаар 7 албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн. Үүний үр дүнд хогийн цэгийг нүүлгэн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж ажилласан.	
76	6.2. Байгаль орчинд ээлтэй бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.	6.2.1. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээнэ.	2021 - 2025		2022 онд Баянхонгор сум 65 га, Өлзийт сум 5 га, Жинст сум 0.7 га, Баянбулаг сум 2 га, Бөмбөгөр сум 1 га, Баян-Овоо сум 0.2 га, Эрдэнэцогт сум 0.36 га талбайд аймгийн хэмжээнд нийт 74.26 га талбайд хамгаалалтын зурвас байгуулан цөлжилт, газрын доройтлыг бууруулсан байна	
77		6.2.2. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд ажилд аймгийн хэмжээнд 6414 иргэн, 537 аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага оролцож нийт 264940 ширхэг мод тарьж, 892.346.600 төгрөгийг зарцуулсан байна. Нийт ногоон байгууламжийн хэмжээг 456 га талбайгаар нэмэгдүүлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 дахин их модыг шинээр тарьж, амьдралтын хувийг 70.8 хувьд хүргэсэн байна.	
78		6.2.3. Байгаль орчны хууль тогтоомжийг олон	2021 - 2025		Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 125 сургалт зохион байгуулж 12503 иргэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, сургуулийн өмнөх боловсролын	

		нийтэд сурталчлан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлэх, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.			хүүхдүүдийг хамруулсан. Мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар 12 удаагийн мэдээллийг улсын болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 300 орчим мэдээллийг цахим хуудсаар мэдээлж давхардсан тоогоор 300.0 мянган хүнд хүргэсэн байна. Мөн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас улсын тусгай хамгаалалтай газар нутаг бүхий 7 сумдын 1328 өрхийн 3200 иргэнд хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, Бугын эвэр түүж бэлтгэхийг хориглосон тухай БОАЖСайдын тушаал, Зөрчлийн тухай хууль, Хууль бус ан, Хог хаягдлын тухай хуулийн талаарх мэдээллийг хүргэж ажилласан.	
79	6.3. Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах	6.3.1. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана.	2021 - 2025		Тайлант онд 3 сумын усан хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны ордыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, 10 сумын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоож, дэглэм мөрдүүлж, газрын доорх усны 2 цооногт мониторинг хийж ажилласан. Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанд хамрагдаж байгаа 10 сумын усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, голын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлсэн. Үүнээс шинээр байршуулсан самбар 5, сэргээн засварласан самбар 8, шаардлага хангаагүй 2 самбарыг буулгаж, дэглэмийг мөрдүүлэн ажилласан. Баянхонгор сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэрт байгаа газрын доорх усны мониторингийн цооног суурилуулсан хяналт шинжилгээний хагас автомат 2 логгерийн дата мэдээллийг нийт 12 удаагийн авч мэдээллийн сан бүрдүүлсэн.	
80	нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.	6.3.2. Газрын байгалийн тогтоц, нуга, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, Байдраг	2021 - 2025		Усан сан байгуулах ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам хамтран "Байдраг гол дээр барих усан цахилгаан станцын ТЭЗҮ боловсруулах" гэрээг "Монхидроконстракшн" ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Тус компани нь гэрээний дагуу ТЭЗҮ-г боловсруулж 2023 оны 06 дугаар сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	

		голыг түшиглэн олон зориулалтаар ашиглах усан сан байгуулна.					
81		6.3.3. Усны нөөц, гидрогеологийн зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн сан бүрдүүлэн усны нөөцөд тохирсон хэрэглээг хэвшүүлнэ.	2021 - 2025			Газрын гүний усны үнэ цэнэ, зөв зохистой хэрэглээ хандлагыг төлөвшүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/55 дугаар тушаалаар "Дэлхийн усны өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хүрээнд 3 төрлийн 17 ажил арга хэмжээг төлөвлөн үр дүнтэй зохион байгуулсан. Үүнд: 1. "Ус ба орчны эрүүл ахуй" сэдвээр 234 сургагч багш, ерөнхий боловсролын сургаалын 100 үе тэнгийн сургагч багш бэлтгэсэн. 2. Сумдын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөний сургалтыг Бөмбөгөр, Богд суманд зохион байгуулж сумдын удирдлага, БОХУБ, байгаль хамгаалагч нийт 73 хүн хамрагдсан. 3. Хүүхдийн Тэмүжин театр усны хомсдол бохирдлын талаар анимейшн киног 500 гаруй хүүхдүүдэд үнэ төлбөргүй үзүүлсэн. 4. ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд усны зохистой хэрэглээний талаар дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан. 5. ЕБС, СӨБ-ийн багш нарын дунд бичил төслийн уралдаан, ахлах ангийн сурагчдын дунд эсээ, илтгэлийн уралдаан, "Чандмань Баянхонгор" ХК-ний харилцагчдын байгууллагын дунд нөлөөллийн ажил зохион байгуулах уралдааныг тус тус зохион байгуулсан. 6. 20 сумын ундны усны эх үүсвэрээс дээж авч, шинжилгээнд хамруулсан. 7. Газрын гүний усны үнэ цэнэ, зөв зохистой хэрэглээний талаар 4 төрлийн шторк бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан. Дээрх олон талт нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 10.000 гаруй иргэд хамрагдсан. Усны нөөц, гидрогеологийн зураглал хийх ажлыг "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө"-нд тусгаж батлуулсан.	

82		6.3.4. Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.	2021 - 2025		<p>“Парисын Хэлэлцээрийн ил тод байдлын тогтолцоо ба Үндэсний тодорхойлсон хувь нэмэр”-ийн хүрээнд орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын уур амьсгалтай холбоотой шийдвэр гаргалтын чадавхыг дээшлүүлэх сургалт зөвлөгөөн 2022 оны 04 дүгээр сарын 04-09-ны өдрүүдэд Төв аймагт зохион байгуулагдсан. Тус сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн холбогдох дарга, мэргэжилтнүүд нийт 4 хүн оролцсон. Тус арга хэмжээнд оролцсон үр дүнд салбарын холбогдох албан тушаалтнууд уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицох, түүнийг бууруулах арга хэмжээ болон уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн талаар нэгдсэн мэдээллийг авч, чадавхажсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санаачилгаар хүлэмжийн хийн ялгарлыг 22.7% хүртэл бууруулах зорилтыг хангах, салбар дундын оролцоог нэмэгдүүлж, аймаг орон нутгийн түвшинд сайн туршлагаудыг дэмжих зорилготойгоор 2022 оны 05 сард зохион байгуулагдсан “Уур амьсгалын өөрчлөлт ба хот” чуулганд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, ахлах мэргэжилтэн нар оролцсон. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвөөс хамтран хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн байгаль орчин болон байгалийн нөөцийн салбарт дасан зохицох чадавхыг бэхжүүлэх” төслийн сургалтыг 2 удаа зохион байгуулж холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл 60 гаруй хүн хамрагдсан. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд 20 сум, 504 аж ахуйн нэгж байгууллага, 6414 иргэн хамрагдаж 264940 ширхэг мод тарьж усалгаа арчилгааг хийсэн.</p>	
83		6.3.5. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж,	2021 - 2025		<p>Ус цаг уурын төвийн Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Бодь, Гурванбулаг, Баянлиг харуулуудыг хагас автомат цаг уурын системээр өргөтгөсөн. Нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээ, хоногийн сэрэмжлүүлэг мэдээ, урьдчилан сэргийлэх мэдээний чанар 98.6 хувь, онч 100 хувь, аюултай үзэгдэл болон гамшигт үзэгдлийг илрүүлсэн</p>	

		цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.			байдал 100 хувьтай байна. Урьдчилан мэдээлэх ажлын үзүүлэлт улсын дунджаас 0.3 хувиар өссөн байна.	
84		6.3.6. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, хог хаягдлын дахин боловсруулалтын үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.	2021 - 2025		Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг хэлэлцэн баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд энэ онд: 1.Баянхонгор сум, Хүрээмарал сум, Заг сум, Баянцагаан сум, Галуут, Гурванбулаг сум тус тус шинэ хогийн цэгийг байгуулж, хашиж хамгаалсан. Мөн Гурванбулаг сум хогийн цэгээ иж бүрэн камержуулсан. 2.Аймгийн хэмжээнд аюултай хог хаягдлын тооллогыг зохион байгуулсан. 3. Уул уурхайн аж ахуйн нэгж, эмнэлгийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад хадгалагдаж байсан 206,7 кг хуурай, 436,6 л шингэн химийн хорт бодисыг "Түмэн эгшиг" ХХК 2022 оны 06 дугаар сард Улаанбаатар хот руу тээвэрлэн мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн. 4. Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг сурталчлах сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг 87 удаа зохион байгуулж нийт 258 төрийн албан хаагчид, 812 иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 2064 сурагчид сургалтад хамрагдаж, Баянбулаг, Заг сум 400 ширхэг гарын авлага бэлтгэн иргэдэд тараан мэргэжил арга зүйгээр ханган ажилласан байна.5. Насан туршийн боловсролын төв, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ, "Цэвэр хот" ОНӨААТҮГ хамтран "Алсын хараа-2050", "Тэрбум мод" үндэсний төслийн хүрээнд ногоон хөгжил, хог хаягдлыг бууруулах чиглэлээр 35 төрийн байгууллага, 5 аж ахуй нэгжийн 80 ажилтан, албан хаагчдад	

					орчны үнэлгээ хийж, төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулсан. Насан туршийн боловсролын төвөөс нэгжийн 22 менежер, “Хог хаягдлын менежмент” сэдвээр сургалт зохион байгуулж, чадавхжуулан сургагч багш бэлтгэсэн. Бэлтгэгдсэн 22 нэгжийн менежерүүд харьяа сургуулийн “Эко” клубийн нийт 24 багш, 218 сурагчдад сургалт зохион байгуулсан.	
7. ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ						
85	7.1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.	7.1.1. Дайчилгааны төлөвлөлтийг төгөлдөржүүлж, бэлэн байдлыг дээшлүүлнэ.	2021 - 2025		Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаал, аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу дайчилгааны даалгавартай ангиудын зөвшөөрөөгүй мэргэжлийн орон тоонуудад I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт, төлөвлөлт, тодотголыг тухай бүрт анги, салбаруудтай хамтран зохион байгуулж явуулсан. Оногдуулан бүртгэгдсэн бэлтгэл үүрэгтэнгүүдийн зөвшөөрөөгүй мэргэжлийг сургалт, тодотгол явуулан үндсэн болон зөвшөөрсөн мэргэжлээр солиход чанар байдалд ахиц гарч, дайчилгааны бэлэн байдал дээшилж байдаг. Мөн эдийн засгийн үзүүлэлт, инфляцийн түвшинг өмнөх оны дүнтэй харьцуулан өөрчлөлт хийн акт үйлдэж дайчилгааны үед зарцуулах үнийн дүнг шинэчилснээр дайчилгааны төлөвлөлт илүү бодитойгоор тусгагдсан.	
86	төлөвлөлтийг шинэчилнэ.	7.1.2. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, цэргийн бэлтгэл сургалтыг боловсронгуй болгоно.	2021 - 2025		Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, 11.8, 19 дүгээр зүйлийн 19.1.8, 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний бэлэн байдлыг шалгах, томилгоот нэгжүүдийг гүйцэтгэх үүрэгт нь дадлагажуулах зорилгоор онолын болон дадлагын хэлбэрээр сургалтыг Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт зэрэг сумдын удирдлагын бүрэлдэхүүнтэй зохион байгуулж явууллаа. Сургалтаар томилгоот нэгжийг удирдах албан тушуултнуудад дайны болон гамшиг ослын үед орон нутгийн хамгаалалтын хууль,	

					төлөвлөгөөний дагуу хэрхэн үүрэг гүйцэтгэн ажиллах талаар онолын ойлголтыг өгч дадлагаар баталгаажууллаа.	
87		7.1.3. Хүүхэд залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025		Аймгийн төвийн ерөнхий боловсролын 5 сургуульд 1911 оны Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны түүх, 1921 оны хувьсгал, 1939 оны халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайны түүх болон орчин үеийн Зэвсэгт хүчний хөгжлийг танилцуулсан хулдаасан хэвлэмэл буланг байгуулсан нь өсвөр үе, хүүхэд залуучуудыг ахмад үе, эх орончдынхоо баатарлаг үйлсээр бахархуулах, эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх эх орон, газар нутгаа хайрлан хамгаалах эрх чөлөө тусгаар тогтнолын үнэ цэнийг мэдрүүлэхэд оршиж байна. ЕБС-ын 10-12 дугаар ангийн сурагчдын дунд “Бид цэргийн хүү” цэрэгжилтийн спорт, “Жагсаалын үзүүлэх тоглолт”, “Бид Эх орны эзэд” ханын сонины уралдааныг 3, 5 дугаар саруудад, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг 5 дугаар сард тус тус зохион байгуулсан. Мөн Үндсэн хууль сурталчлах өдөрлөг, Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны өдрийн цэцэг өргөх ёслолын арга хэмжээний үеэр цэргийн насны залуучуудын төлөөлөлд болон ерөнхий боловсролын 12 дугаар ангийн 18 нас хүрсэн сурагчдад цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулан өгсөн. Ерөнхий боловсролын сурагчид, иргэд олон нийтэд Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах, цэрэг-эх оронч хүмүүжил олгох, Монгол цэргээрээ бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн өв тэгш хүмүүжил олгох зорилгоор Зэвсэгт хүчний 339 дүгээр ангитай хамтран аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээнийг зохион байгуулж давхардсан тоогоор 480 сурагч хамрагдсан	
88	7.2. Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоо,	7.2.1. Улсын хил хамгаалалт, албаны бэлэн байдлыг	2021 - 2025		Хил хамгаалах 0166 дугаар ангийн Хатан суудал, Сэгс цагаан богд 2 заставын байрны засвар болон үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс нийт 25.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, тэнд ажиллаж байгаа албан хаагчдын ажиллах амьдрах орчин нөхцөл сайжирсан.	

	бүсчилсэн хил хамгаалалтыг дэмжин, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	дээшлүүлэхэд хамтран ажиллана.				
89	7.3. Иргэдийн аюулгүй байдлын түвшинг нэмэгдүүлнэ.	7.3.1. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна.	2021 - 2025		Тухайн онд иргэн хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 5263 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн өмнөх оны мөн үеийнхээс 747 буюу 16.5 хувиар өссөн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 122 буюу өмнөх онтой харьцуулбал 49 нэгжээр буурсан байна Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 27 буюу өмнөх онтой харьцуулбал 8 нэгжээр өссөн байна. Малын хулгайн гэмт хэрэг 33 буюу өмнөх онтой харьцуулбал 12 нэгжээр өссөн байна. . Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг 41 буюу өмнөх онтой харьцуулбал 5 нэгжээр буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 1.5 пунтээр өссөн байна.	
90		7.3.2. Иргэдийн Эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	2021 - 2025		Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж 11.000.000 төгрөг төсөвлөж, 6 зорилт, 31 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан. Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум, 80 байгууллагын 9500 гаруй иргэд, төрийн албан хаагчдад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, захиалгат танхимын сургалтыг зохион байгуулж анхан шатны зөвлөгөө мэдээллийг 8000 гаруй иргэнд өгч ажилласан. Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран	

					аймгийн хэмжээний 214 эрх зүйн хөтчийг бэлтгэсэн. Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахимаар болон танхимаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэн ажилласан.	
91	7.3.3. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна.	2021 - 2025			Орон нутагтаа Архив, бичиг хэргийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг зохион байгуулан "Тэнгэр дээд" сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулснаар тайлант онд 28 ажилтан төгсөж, эчнээ ангид 55 ажилтан, өдрийн ангид 8 оюутан үнэ төлбөргүй суралцаж байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж, стандартын талаарх мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор "Архив албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэл" сургалтыг байгууллагын дарга, эрхлэгч, албан хаагч, архив, бичиг хэргийн ажилтнуудад 13 удаа танхимаар 8 удаа онлайнаар зохион байгуулж нийт давхардсан тоогоор 2599 хүний мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн. Баянхонгор аймаг дахь Төрийн архивын сан хөмрөгийн баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангахаар "Айети юнипикэшн" ХХК-тай шууд гэрээ байгуулан 17.0 сая төгрөгийн үнэ бүхий 53 ширхэг камерыг сан хөмрөгт тавьж хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих боломжийг бүрдүүллээ.	
92	7.3.4. Дэвшилтэт технологи бүхий гэрэлтүүлэг, камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр	2021 - 2025			Баянхонгор сумын ОНХ сангийн хөрөнгөөр 190.0 сая/ өртөг бүхий нийтийн эзэмшлийн 48 цэгт тээврийн хэрэгслийн улсын дугаар таних 4, хөдөлгөөнт 13, 24 цагийн турш өнгөтөөр харах 31 ширхэг дэвшилтэт технологи бүхий камержуулалтын ажлыг хийж, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэн ажиллаж байна.	

		гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.				
8. НАЙМ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ						
93	8.1. Сум, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	8.1.1. Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломжийг бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аюулын эрсдэл өндөртэй сумдад байгуулна.	2021 - 2025		Баацагаан сумын Баянсайр цаг уурын харуулын өртөөнд агаар, хөрсний температур, чийг, тунадас хэмжигч цаг уурын автомат Q1000 станцыг байрлуулсан. Ингэснээр Дэлхийн цаг уурын гэрээний дагуу олон улсын цаг уурын мэдээллийг минут, секундээр гаргаж олон улсын цаг уурын байгууллагад мэдээлэх боломж бүрдсэн. Нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээ, хоногийн сэрэмжлүүлэг мэдээ, урьдчилан сэргийлэх мэдээний чанар 98.6 хувь, онч 100 хувь, аюултай үзэгдэл болон гамшигт үзэгдлийг илрүүлсэн байдал 100 хувьтай байна. Урьдчилан мэдээлэх ажлын үзүүлэлт улсын дунджаас 0.3 хувиар өссөн байна.	
94		8.1.2. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон	2021 - 2025		"Aeromongolia" ХХК нь 2021 оны байдлаар долоо хоногт 1 удаа нислэг үйлддэг байсан ба Улаанбаатар-Баянхонгор, Баянхонгор-Улаанбаатар чиглэлд 24 нислэг үйлдсэн ба нисэх буудлын хэмжээнд 54 нислэг хийгдсэн. Коронавирусын цар тахал болон нисэх буудлын барилгын засвартай холбоотойгоор 2021 оны 6-р сард нислэгийн үйл ажиллагааг зогсоосон. 2022 онд шатахууны нэмэгдэлтэй холбоотойгоор нислэг хийгээгүй ба нислэгийн хуваарь тов гараагүй байна	

		улсын стандартад хүргэнэ.				
95		8.1.3. Инновац, дэвшилтэт техник технологи, дижитал шилжилтийг АТҮТөвд нэвтрүүлж ухаалаг тээврийн нэгдсэн тогтолцоог хангуулж ажиллана.	2021 - 2025			Баянхонгор аймагт ачаа тээвэрлэж байгаа авто машин бүрд QR код олгож хот, аймаг хооронд ачаа тээвэрлэлт хийх бүрд www.teeverzuuch.mn сайтад бүртгэлжүүлэн ажилласан. Мөн ачаа тээврийн logistic.transdep.mn программд давхар бүртгэж замын хуудас болон QR кодыг олгож тээвэрлэлтэд хяналт хамгаалалт тавьж байсан. QR кодыг олгож ажилласнаар хяналт өндөрсөж ачаа тээврийн үйл ажиллагааг зохион байгуулж иргэдийн ачаа мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэсэн. Энэ нь Корона вирус цар тахлын үед аймгийн иргэн, аж ахуйн нэгж хүнсний хомсдолд орохгүй байх үндэслэл болсон. Баянхонгор аймгийн төвийн доторх нийтийн тээврийн үйлчилгээний зориулалттай 4 чиглэлд 8 Эко автобус явуулсан. Ингэснээр иргэдийн ая тухтай зорчих боломж бүрдэж эко автобусанд цахим зорчих тасалбар нэвтрүүлэх судалгаа хийгдсэн
96		8.1.4. Зарим сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025			Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Бридж бюлдин" ХХК шалгаран, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан. Зураг төслийн ажлыг "Гидрогеодизайн инновац" ХХК гүйцэтгэн 2 км автозамын зураг төслийн ажлыг боловсруулан батлуулсан. 2022 онд 60-70 м3 хүчин чадалтай "Эколос"-ын бага оврын цэвэрлэх байгууламж, төрийн 5 байгууллагад шинээр стандартын ариун цэврийн өрөө хийх, Гадна тохижилтын ажил, Тоглоомын талбай, Спорт талбай, Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, 800 м урттай дугуйн зам, 2.5 км авто зам, 2.5 км урттай бохирын шугам, Усан хангамжийн эх үүсвэрийн 25м3 багтаамжтай нөөцийн сав /Хуучин эх үүсвэр ашиглах/, Цэвэрлэх байгууламж ажиллуулах цахилгааны дэд станц, камержуулалтын ажлууд хийгдэх бөгөөд шугам сүлжээний угсралтын ажлууд хийгдсэн. Энэ онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтад "Алегротонер констракшн" ХХК шалгарсан бөгөөд Түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан. Сумын төвийн шинэчлэлийн ажлын

					<p>зураг төсөл боловсруулах ажлыг “Алтайн газрын хүч” ХХК гүйцэтгэж дууссан бөгөөд Барилгын хөгжлийн төв дээр магадлалын дүгнэлт гаргуулахаар хянагдаж байна. Тус төслийн хүрээнд 2 км авто зам /гэрэлтүүлэг, камер, ногоон байгууламжтай/ 2 км дугуйн зам, 2 км явган зам, Бохирын шугам 2 км, 60м3 багтаамжтай цэвэрлэх байгууламж, Цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг, 60м3 багтаамжтай нөөцийн сав, 2км урттай цэвэр болон дулааны шугамын ажлууд хийгдсэн. 100м*70м, 90м*60м талбайтай 2 цэцэрлэгт хүрээлэн, Албан байгууллагуудын ариун цэврийн өрөө шинээр хийх /6 байгууллагын барилгад 12 нойлын өрөө/ ажлууд энэ онд хийгдэнэ. Баацагаан сумын СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ-ийн сонгон шалгаруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зохион байгуулж, “Рино инженеринг” ХХК шалгаран 5 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан. 2023 оны 05 дугаар сард шугам сүлжээний ажлыг эхлүүлнэ.Эдгээр ажлууд хийгдсэнээр сум орон нутаг ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдэнэ.</p>	
97	8.1.5. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана.	2021 - 2025		<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/54 тоот захирамжийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 10-28-ны өдрүүдэд 20 сумын ундны усны эх үүсвэрээс дээж авч, “Монгол –Ус” ТӨҮГ-ын дэргэдэх усны хяналтын төв лабораторид химийн 15 элемент, хүнд металл 6 элементийн шинжилгээнд хамруулсан. Мөн 20 сумын ундны усны эх үүсвэрүүдийг үүсвэрт хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж, зураглал хийлгэхэд Баянбулаг, Шинэжинст, Гурванбулаг сумдаас бусад нь хамгаалалтын бүсийн дэглэмийг хангахгүй байсан тул зөвлөмжийг хүргүүлсэн. Түйн голын онцгой хамгаалалтын бүсэд-2 ш, дунд булгийн онцгой хамгаалалтын бүсэд-1 ш, Шаргалжуутын рашааны онцгой хамгаалалтын бүсэд-2 ш нийт 5 ширхэг мэдээллийн самбарыг шинээр байршуулсан. Жаргалант сумын Хүрэн үзүүр, Цагаан худагт-2ш, Өлзийт сумын нутаг Шаргалжуутын гол дагуу-6 ширхэг нийт 8 усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн тэмдэгжүүлэх самбаруудыг сэргээн засварлан байршуулж иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэсэн.</p>		

98		8.1.6. Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдыг дагуул сум болгон хөгжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулна.	2021 - 2025		Аймгийн төвийн тойргийн сум болох Өлзийт, Эрдэнэцогт Галуут сумдад "Сумын төвийн шинэчлэл" төсөл хэрэгжиж нийт тус тус бүр 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Эколос”-ын бага оврын цэвэрлэх байгууламж, төрийн байгууллагад шинээр стандартын ариун цэврийн өрөө, гадна тохижилтын ажил, тоглоомын талбай, спорт талбай, цэцэрлэгт хүрээлэн, 2.5 км авто зам, ногоон байгууламж, дугуйн зам, 2.5 км урттай бохирын шугам, усан хангамжийн эх үүсвэрийн 25м3 багтаамжтай нөөцийн сав, цэвэрлэх байгууламж ажиллуулах цахилгааны дэд станц, камержуулалтын ажлууд хийгдэх бөгөөд шугам сүлжээний угсралтын ажлууд хийгдэж дэд бүтцийг бүрэн шийдвэрлэн ажилласан. Тухайлбал: Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэл 2022 онд 60-70 м3 хүчин чадалтай “Эколос”-ын бага оврын цэвэрлэх байгууламж, төрийн 5 байгууллагад шинээр стандартын ариун цэврийн өрөө хийх, Гадна тохижилтын ажил, Тоглоомын талбай, Спорт талбай, Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, 800 м урттай дугуйн зам, 2.5 км авто зам, 2.5 км урттай бохирын шугам, Усан хангамжийн эх үүсвэрийн 25м3 багтаамжтай нөөцийн сав /Хуучин эх үүсвэр ашиглах/, Цэвэрлэх байгууламж ажиллуулах цахилгааны дэд станц, камержуулалтын ажлууд хийгдэх бөгөөд шугам сүлжээний угсралтын ажлууд хийгдэж байна.	
99		8.1.7. Олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		Оготнойтой булгийн зам дагуу 600м талбайд унадаг дугуйн зам барих ажлыг 2021 онд “Их Богд зам” ХХК бүрэн хийж гүйцэтгэсэн.Мөн спорт цогцолборт байрлах Крикетийн талбайг тойруулан 1.2 км стандартад нийцсэн унадаг дугуйн замыг 2022 онд барьж ашиглалтад оруулж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлсэн.	
100		8.1.8. Залуус хороолол болон Шинэ суурьшлийн бүсийн инженерийн	2021 - 2025		Залуус амины орон сууцны хорооллын гадна шугам сүлжээ болон Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний (2, 3, 4, 5, 6, 7, 9-р баг) ажлын зургийг “ДНТ” ХХК гүйцэтгэн 2022 онд хүлээлгэн өгсөн. Шинэ суурьшлын бүсийн цэвэр усан хангамжийн 4.5 км шугам	

		шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.			сүлжээ, хоногт 500м3-ийн хүчин чадалтай усан сан, 128м3-ийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Мөн улсын төсвийн 7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Гал хонгор" ХХК инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлээд байна. Тус ажил 2023 оны 4 улиралд ашиглалтад орно.	
101		8.1.9. Аймгийн ашиглалтын шаардлага хангахааргүй болсон хуучин барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх, өнгө үзэмжийг сайжруулах, гадна орчны тохижилт хийх, инженерийн шугамыг шинэчлэх, оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж үйлчилгээг СӨХ-д шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	2021 - 2025		Ашиглалтын шаардлага хангахгүй болсон хуучин байрыг дахин төлөвлөлтөд оруулах ажлыг 2017 оноос эрчимтэй хэрэгжүүлж 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн 1120,0 сая төгрөгөөр санхүүжилтээр Баянхонгор сумын Номгон 1-р багийн 10-р байрыг дахин төлөвлөлтөд оруулсан. Мөн 2022 онд Баянхонгор сумын Рашаант 10-р багийн 2,7,9 дүгээр байрны дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлж 1-р ээлжийн 2 блок 80 айлын орон сууцны барилгыг 2023 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Нийтийн орон сууцыг дахин төлөвлөлтөд оруулснаар иргэдийн ая тухай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлээд байна.	
102	8.2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн	8.2.1. Малын чанар, ашиг шимийг сайжруулах, малын тоог чанарт шилжүүлж "Монгол мал-2", "Монгол малчин" үндэсний	2021 - 2025		"Монгол мал-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх төрлийн малын сүргийн эргэлт, төлөвлөлтийг тооцон ажиллаж байна. Баянбулаг омгийн хонь, Бөмбөгөрийн улаан омгийн ямааны үржлийн ажлын стратеги, төлөвлөгөөг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан.Залаажинст-Эдрэнгийн цагаан ямааны үржлийн ажлын стратегийг эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Хүнс, хөдөө аж ахуй,	

	эргэлтийг эрчимжүүлнэ.	хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.			<p>хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлөөр оруулж батлуулахаар төлөвлөж байна. Ламын гэгээний улаан тэмээний үржлийн ажлын стратегийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулсан.</p> <p>Баталгаажсан үүлдэр омгийн малын удмын санг хамгаалах, генийн санд баяжилт хийх зорилгоор Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран ажиллаж, Бөмбөгөрийн улаан омгийн ямааны 3-5 насны 3 өсвөр хээлтүүлэгчээс 2500 үрийг авч малын генийн санд хадгалан, хамгаалалтад авсан. "Монгол Малчин "үндэсний хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба нийт 5 зорилт, 14 арга хэмжээг хяналтад авч 92,4%-иар биелүүлэн ажиллалаа.</p> <p>Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг хангах зорилгоор Хөдөө, аж ахуйн их сургууль, Аймгийн Засаг дарга, Сумын Засаг дарга, суралцагч нар хамтарсан гэрээ байгуулан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр оюутны сургалтын төлбөрийн 50 хувийг дааж дэмжлэг үзүүлсэн. 2021-2022 оны хичээлийн жилд агрономич 1, малын их эмч 2, мал зүйч буюу зоотехникчээр 16 оюутан нийт 12 оюутан суралцахаар гэрээ байгуулан сургалтын төлбөрт нийт 27,2 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр шийдвэрлэсэн. Дээрх 19 оюутнаас 1 оюутан энэ онд сургуулиа амжилттай төгсөж Баянбулаг сумын Хөдөө аж ахуйн тасагт мэргэжилтнээр ажиллаж байна."</p>	
103		8.2.2. Бэлчээр ашиглалт хамгаалалтыг сайжруулж, өнжөөж чөлөөлөх, усжуулах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	2021 - 2025		<p>2021-2022 онд нийт 34 худаг ашиглалтад орж дунджаар 51,0 мянган га бэлчээр усжуулагдаж 35,0 мянган толгой мал усаар хангагдсан. Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх зорилгоор улсын болон аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бактержуулсан бэлдмэл авч нийт 100 тн бэлдмэлийг хангайн сумдын 77.0 мянган га-д цацсанаар техникийн үр дүнг 90% буюу "үр дүнтэй" дүгнэгдсэн. Мөн Улсын төсвийн 80,0 сая төгрөгийн хөрөнгөөр бэлчээрийн хортон мэрэгчтэй энгийн механик аргаар тэмцэх ажлыг Гурванбулаг, Баянбулаг, Бөмбөгөр, Жаргалант, Заг сумдын 31,5 мянган га талбайд гүйцэтгэсэн.</p>	

104		8.2.3. Услалтын системийг бүрэн ажиллуулж тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулж, малын тэжээлийн ургамал тариалж дотоодын хэрэгцээг ханган, газар тариалан эрхлэлтийг дэмжиж төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025		<p>2021 онд Бумбатын талбайд тог цахилгаанд холбох шугам сүлжээг сайжруулан гүн өрмийн 3 худгаас нийт 35 га талбайг услах боломжийг хангасан. Нийт 4.8 га талбай услах хүнсний ногооны бага оврын бороожуулагч 4 ширхэг, 9 га талбай услах 3 иж бүрэн зөөврийн услалтын систем, 10 га талбай услах хүчин чадалтай 2 ширхэг услалтын систем нийт 23.8 га талбайг услах хүчин чадалтай 3 төрлийн услалтын системүүд нийлүүлэгдсэн. Мөн 292.6 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалан 40.6 хувийн ашиглалттай тариалангийн талбайг ашигласан. 2022 онд төмс 232.0 га-аас 1720 тн, хүнсний ногоо 152.3 га-аас 785.0 тн, тэжээлийн ургамал 241.0 га-аас 323.0 тн, жимс жимсгэнэ 11.5 га-аас 30.8 тн ургац хураан авч ургац хураалтын ажил бүрэн дууссан. Хүнс амын хүнсний ногооны 11,2%, төмсний 53.6%-ийг хангаж байна.</p> <p>Хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлж, өрхийн тариалангийн үйл ажиллагааг өргөжүүлэн хүн амын хүнсний хангамжийг өсгөх зорилтын хүрээнд 5 сумын 27 иргэн нийт 736 м2 37.5 сая төгрөгийн хүлэмжийг өөрсдийн хөрөнгөөр худалдан авч компанийн зүгээс 3,5 сая төгрөгийн 27 ширхэг услалтын системийг үнэ төлбөргүйгээр өгч дэмжлэг үзүүлсэн. Баянцагаан сумын Цагдуултайн услалтын системийг сайжруулан 25 га талбайд тэжээлийн ургамал тариалж 30 тн ургац хураан авсан. Баянлиг сум услалтын системийн нуураа засварлаж тариалалтын талбайгаа нэмэгдүүлж аймгаас 8.6 сая төгрөгийн усалгааны тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, төмс хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалж усалгаагаар хангах нөхцөлийг бүрдүүлсэн. Баянговь сум Цагаан голын услалтын системийг түшиглэн 10 га талбайд хэрэгжүүлэн малчдын бүлэг нөхөрлөл өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх эхлэлийг тавьсан. Тариалалтын дүнгээр инженерийн хийцтэй услалтын системүүдийн ашиглалт 21 хувь, хүнсний ногоо 7 га, төмс 12 га тэжээлийн ургамал 58 га-аар нэмэгдсэн байна.</p>	
105	8.2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн	8.2.4. Малын халдварт, гоц халдварт,	2021 - 2025		2021-2022 онд мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 4.1 сая толгой малыг хамруулсан. Мөн Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх масс дархлаажуулалтад нийт 229.2	

	нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлнэ.	шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж эрүүл бүс статусаа бататгана.				мянган толгой мал, амьтныг хамрууллаа. Дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулснаар мал, амьтны гоц халдварт өвчингүй ногоон бүс болсон. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 20 сумын 3.9 сая толгой малыг хамруулж 83% гүйцэтгэлтэй биелүүллээ.	
--	---	---	--	--	--	--	--